



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**



Боловсролын хүрээлэнгийн захирлын
2019 оны 9 дүгээр сарын 26 өдрийн
тоот тушаалын гуравдугаар хавсралт

**БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ЗААВАЛ СУДЛАХ, СОНГОН СУДЛАХ МОНГОЛ ХЭЛ,
ҮНДЭСНИЙ БИЧИГ, УРАН ЗОХИОЛ, МАТЕМАТИК, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,
ФИЗИК, БИОЛОГИ, ХИМИ, ГАЗАР ЗҮЙ, НИЙГЭМ СУДЛАЛ, АНГЛИ ХЭЛ, ОРОС
ХЭЛНИЙ БОЛОН ЗААВАЛ СУДЛАХ МОНГОЛЫН ТҮҮХ, БИЕИЙН ТАМИР, ДИЗАЙН
ЗУРАГ ЗҮЙ, ТЕХНОЛОГИ, СОНГОН СУДЛАХ ТҮҮХ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИЙН
САЙЖРУУЛСАН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

(Бүрэн дунд боловсрол X-XII анги)

Улаанбаатар
2019



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

**Бүрэн дунд боловсрол X анги
(Заавал болон сонгон судлах хөтөлбөр)**

Улаанбаатар
2019

“Монгол хэл бичиг, уран зохиол”-ын сургалтын цөм хөтөлбөр (2016)

Багийн ахлагч:

Ш.Оюунцэцэг

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Хэл, нийгэм хүмүүнлэгийн ухааны Сургалтын албаны дарга, магистр

Багийн гишүүд

Монгол хэл:

М.Базаррагчаа

Sc.D., профессор, МУИС, Монгол хэлний тэнхимийн багш

Б.Мөнгөнцэцэг

Ph.D., МУИС, Монгол хэлний тэнхимийн багш

Б.Оюунцэцэг

магистр, Боловсролын хүрээлэнгийн ЭША

Ц.Өнөрбаян

Sc.D., профессор, МУБИС, МСТ-ийн эрхлэгч

Ц.Туул

магистр, Шинэ-Эрин сургуулийн багш

Б.Цасанчимэг

магистр, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч

Ө.Цэндсүрэн

магистр, Нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн

А.Энхнаран

магистр, Байгаль эх лицей сургуулийн багш

Д.Эрдэнэсан

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Уран зохиол:

Г.Галбаяр

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн

эрхлэгч

магистр, Нийслэлийн 11 дүгээр сургуулийн монгол хэлний багш

Ц.Март

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн багш

Г.Нандинбилиг

Ph.D., МУБИС, УЗ-ын тэнхимийн багш

П.Нармандах

Ph.D., МУБИС, УЗ-ын тэнхимийн багш

П.Одсүрэн

Ph.D., Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч

Д.Туяа

Ph.D., Шинэ-Эхлэл сургуулийн багш

С.Энхбаяр

ScD., профессор, МУБИС, УЗСЗ-н тэнхимийн эрхлэгч

Үндэсний бичиг:

Ү.Ариунболд

Ph.D., дэд профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Д.Баттогтох

Ph.D., Боловсролын хүрээлэнгийн ЭША

Б.Батчимэг

Нийслэлийн 23 дугаар сургуулийн багш

Н.Мөнхцэцэг

Нийслэлийн 39 дүгээр сургуулийн багш

Д.Соронзон

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Хөндлөнгийн шинжээч:

А.Цог-Очир

Ph.D., профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Ц.Оюун

Sc.D., профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Д.Эрдэнэсан

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

А.Энхнаран

магистр, Байгаль эх лицей сургуулийн багш

Б.Сүхболд

ЕБ-ын 33 дугаар сургуулийн багш

Д.Соронзон

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Г.Нандинбилиг

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн багш

Ш.Оюунцэцэг

магистр, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Хэл, нийгэм хүмүүнлэгийн ухааны Сургалтын албаны дарга

Л.Цэдэнсодном

Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Хянан тохиолдуулсан (2019)

Л.Цэдэнсодном

Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

10 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ЗААВАЛ СУДЛАХ СУРГАЛТЫН ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙН ЗӨВЛӨМЖ

Энэхүү баримт бичиг нь монгол хэл бичгийн заавал судлах шинэчилсэн хөтөлбөрийн дагуу аравдугаар ангид хичээл сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зааж хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт хийхэд, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой удирдамж болно.

УНШИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.1а. Тайлбарласан эсээ, хөрөг найрууллын сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэр, цогцолбороор тодорхойлох</p>	<p>Тайлбарласан эсээ, хөрөг найрууллын сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэр, цогцолбороор тодорхойлохын тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Агуулгыг ерөнхийлөн баримжаалах. Үүний тулд: - Урьдчилсан дүр төрхийг гаргах - Гарчгийг уншиж агуулгын талаар таамаг дэвшүүлж, ярилцах - Ямар нэг тайлбар, зураг дүрс, хүснэгт, график, диаграмм байгаа эсэхийг ажиглах. - Хэрэв байвал өгөгдлүүдийг уншаад юуны тухай мэдээлэл болохыг хэлэлцэх - Дэд гарчиг байгаа эсэхийг ажиглах. Тухайн дэд сэдвүүд ямар асуудлыг хамруулан үзсэнийг тунгаан бодох - Эхийг цогцолбороор хэсэглэх - Эхний болон төгсгөлийн цогцолборыг унших. Эхлэл хэсэгт хөндсөн асуудлыг төгсгөл хэсэгт хэрхэн дүгнэснийг ойлгож, ярилцах - Түлхүүр үг, өгүүлбэрийг олох. Түүгээр баримжаалж, эхийн ерөнхий утгыг хэрхэн ойлгосноо ярилцана. - Түлхүүр өгүүлбэрийг ашиглан эхийн агуулгыг хураан найруулж бичих - Эхийн агуулгыг схем, диаграм, хүснэгт зэрэгт оруулж бичих <p>Багшид зөвлөх нь: Эхийг уншаад агуулгыг ерөнхийлөн баримжаалах: Эсээ, хөрөг найруулал зэргээс гадна тайлбар дүрс, схем диаграмм, график бүхий эхийг сонгохоос гадна дэд гарчиг бүхий эхийг сонгох нь зүйтэй. Учир нь эхийн агуулгыг ерөнхийлөн баримжаалж унших нь судлан уншихаас арай өөр юм. Өөрөөр хэлбэл нэгд нэгэнгүй унших шаардлагагүй. Зөвхөн өөрт хэрэгтэй мэдээлэл хайх үед хэрэг болох чадвар юм. Тиймээс гарфикаас, хүснэгтээс, схем диаграмм, тайлбар зэргээс юуны тухай болохыг ерөнхийд нь таниад судалж унших шаардлагатай эсэхээ шийдэхэд дөхөм болно. Мөн эхээс түлхүүр үгийг олж уншиж сурахад анхаарна. Сэдэв ба утгыг тайлан тайлбарлах, дүгнэлт гаргах Гол ба дэмжсэн дэд сэдвүүдийг тодорхойлж сурахад анхаарна. Эх зохион бичих, мэдээлэл цуглуулан, асуудал дэвшүүлэн эх зохиох, найруулж бичихэд хүүхдүүдийн хамгийн их алддаг зүйл бол сэдэв сонгох,</p>	<ol style="list-style-type: none"> 1. Д.Дэнсмаа “Мал жаргаах ухаан” 2. Ш.Цэрэнпил “Хэнээт” 3. Д.Батбаяр “Үнэлэх” 4. Л.Хэрлэнтуяа “Нэр төр” (хэсгээс) 5. Д.Батбаяр “Өс өвөрлөх” 6. Л.Түдэв “Нэр” (хэсгээс) 7. Д.Батбаяр “Үг” 8. Л.Түдэв “Дулаарлын айдас” 9. Л. Түдэв “Гүйдэл” 10. Л.Түдэв “Хурд нэмэх жам” 11. М.Монтень “Нэг л үр дүнд янз бүрийн аргаар хүрч болдог” 12. Л.Түдэв “Хувь хүний засгийн газар” 13. Л.Түдэв “Газрын юм” 14. Б.Ринчен “Номын садан” 15. Л.Түдэв “Эргүүлгийн тухай эргэцүүлэл”

	<p>түүнийг дэмжсэн сэдвүүдийг тодорхойлохдоо тааруу байдаг явдал юм. Тиймээс уншсан эхээс гол ба дэмжсэн сэдвүүдийг тодорхойлж, түүнийгээ схемээр илэрхийлж сургавал сайн. Учир нь дараа нь ямар нэг сэдэв сонгоод бичих болбол ерөнхий төлөвлөгөөгөө схемчилж гаргаж сурахад оршино.</p> <p>Утгыг хэр ойлгосныг түлхүүр үгсийг түүлгэх, өөрийн үгээр хураан бичүүлэх, цогцолбор тус бүрийн түлхүүр өгүүлбэрийг олж найруулах замаар хураан товчлох зэргээр хэрэглээ рүү чиглүүлнэ.</p> <p>Зарим хүүхдүүд дүгнэлт гаргахдаа эхлэл, гол хэсэгт байгаа зарим санаануудыг давтаж дүгнэлт гаргадаг. Тэгвэл сурагчдаар дүгнэлт гаргаж сургахын тулд:</p> <ul style="list-style-type: none"> • Уншигчдыг өдөөсөн тухайн сэдэв, гол санаатай холбоотой эсвэл эсрэгцүүлэн сэргүүлсэн асуулт байж болно. • Зарим нэг зүйл, шинэ санааг санал болгож болно. • Өөр нөхцөл байдалтай харьцуулсан маягаар дүгнэж болно. • Уншигчдад хамгийн гол, чухал хэрэгтэй зүйл нь юу вэ? гэдгийг ойлгуулах үүднээс дүгнэж болно. • Ирээдүйгээ харсан санал, дүгнэлтийг бичих • Өмнөх санаагаа хурааж бичих юм уу, санаагаа давтах нь дүгнэлт биш гэдгийг ойлгуулах <p>Эхийн сэдэв гол санааг тодорхойлох, үзэл бодол, сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэх, соёлын үнэт зүйлийг тодорхойлохдоо</p> <p>эхийг бүтээсэн аргыг сайн судлах хэрэгтэй.: Үүний тулд 2 ба түүнээс дээш эхийн жишээг сонгон ажиллуулж, харьцуулан судлуулж болно. Харьцуулахдаа венийн диаграммын арга, хүснэгтийн зэрэг аргаар судлуулж болох юм.</p> <p>Их мэдээллийг агуулсан том хэмжээний ном зохиол, бичвэрийн дотроос өөртөө хэрэгтэй мэдээллийг олохын тулд та гүйлгэн уншвал илүү үр дүнд хүрнэ. Үүний тулд эхлээд урьдчилсан дүр төрхийг гаргах хэрэгтэй болно. Ингэхийн тулд дээр заасан үйл ажиллагаануудаас хийгээд үзээрэй. Энэ арга барилд суралцсанаараа мэдээллийг нэг бүрчлэн уншиж цаг алдахгүй, зөвхөн өөртөө хэрэгтэй мэдээллээ тоймлон авна. Мөн тухайн сэдэв, гол санааг гаргаж авснаар цааш унших уу, үгүй юу гэдгээ шийдэж болно. Тиймээс хүнд маш хэрэгтэй чадвар юм. Энэ чадварт сургахын тулд эхээ сонгохдоо тайлбар дүрс, схем диаграмм, графиктай, мөн дэд гарчиг бүхий эхийг сонгох нь зүйтэй. Учир нь эхийн агуулгыг ерөнхийлөн баримжаалж унших нь судлан уншихаас арай өөр юм. Мөн эхээс түлхүүр үгийг олж уншиж сурахад анхаарна.</p> <p>Гол ба дэмжсэн дэд сэдвүүдийг тодорхойлж сурахад бас анхаараарай. Эх зохион бичих, мэдээлэл цуглуулан, асуудал дэвшүүлэн эх зохиох, найруулж бичихэд</p>	<p>16. Л.Түдэв “Оюуны лус”</p> <p>17. Д.Батбаяр “Нууцын нууц”</p> <p>18. Ч.Эрдэнэ “Хас ба хос”</p> <p>19. Л.Түдэв “Үхэр хулгана –харх”</p> <p>20. Д.Батбаяр “Мөс”</p> <p>21. Л.Түдэв “Дэлгэцийн дээрэмчин”</p> <p>22. Д.Нямаа “Мэргэний хөндийд дөрвөн цаг эгшиглэнэ”</p> <p>23. Л.Түдэв “Өргөс”</p>
--	--	--

	<p>хүүхдүүдийн хамгийн их алддаг зүйл бол сэдэв сонгох, түүнийг дэмжсэн сэдвүүдийг тодорхойлохдоо тааруу байдаг явдал юм. Тиймээс уншсан эхээс гол ба дэмжсэн сэдвүүдийг тодорхойлж, түүнийгээ схемээр илэрхийлж сургавал сайн. Учир нь дараа нь ямар нэг сэдэв сонгоод бичих болбол ерөнхий төлөвлөгөөгөө схемчилж сурах юм.</p> <p>Утгыг хэр ойлгосныг түлхүүр үгсийг түүлгэх, өөрийн үгээр хураан бичүүлэх, цогцолбор тус бүрийн түлхүүр өгүүлбэрийг олж найруулах замаар хураан товчлох зэргээр унших арга барил руу чиглүүлнэ.</p>	
<p>10.16. Тайлбарласан эсээ, хөрөг найруулал, ажлын удирдамж, тайлангийн бүтэц, агуулгын уялдаа холбоо, учир зүйн дарааллыг цогцолбор, догол мөрөөр тайлбарлах</p>	<ul style="list-style-type: none"> - Эхийг бүхэлд нь гүйлгэн унших, чухал хэсгийг сонгож чанга тод унших, бүхэлдээ юуны тухай өгүүлж байгааг тодруулах - Эхийн гол санаа болон гарчгийн уялдаа холбоог тодорхой тайлбарлан үзэл бодлоо илэрхийлэх, зохиогчийн зорилгыг тодорхойлсон тайлбар гаргах - Эхэд юуны тухай өгүүлж байгааг тодорхой тайлбарлахдаа уул эхээс жишээ татах - Эхийн гол санааг тодорхойлохдоо түүнийг дэмжиж буй мэдээллүүдийг ялгаж илрүүлэх, дарааллыг тогтоох - Мэдээллүүд нь эхийн гол утга санааг хэрхэн баяжуулж байгааг тодруулах: Тухайлбал: Эсээнд гол утга санааг тодруулах явцдаа зохиогч дэвшүүлсэн асуудлаа нотлохын тулд ашигласан дэмжигч мэдээллүүдийг тодруулж унших, ямар дарааллаар байрлуулсныг тодорхойлох - Өгүүлэгчийн үзэл бодол, нотолгоо баталгааг дэмжиж буй мэдээллүүдийг ялгаж тайлбарлах, эхийг товчилж хураангуйлах - Эхийн доторх үгсийн ил ба далд утгыг ойлгох, тайлбарлах - Эхийн өвөрмөц шинжийг илэрхийлсэн жишээг олж тодорхойлох, тэмдэглэх, үр дүнг нэгтгэх, хэлэлцэх - Эхэд дэвшүүлсэн асуудлаа гол санаагаараа хэрхэн илэрхийлж гаргасан буюу эхийн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоог тодруулах - Зохиогч эхийнхээ аль нэг хэсэгт, эсвэл аль нэг үгээр дэвшүүлж буй асуудлаа илэрхийлснийг олох. - Үнэлж дүгнэхэд өөрийн үзэл бодол чухал болохыг ойлгох <p>Багшид зөвлөх нь: Эхийг агуулгын бүрэлдэхүүн хэсгээр нь ялгахын тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Эхийн агуулгыг хэдэн хэсэгт хувааж болохыг тогтоох, шинжлэх - Эхийн агуулгыг баримт мэдээлэл, зохиогчийн үзэл бодол гэсэн хэсэгт ялган ангилж унших - Эхээс чухал ба чухал бус мэдээллийг ялгах, ангилах - Эхийн үйл явдал, зохиогчийн үзэл бодол, хэлэх гэсэн санаа зэргийг эхэд хэрхэн байрлуулсан ерөнхий бүтцийг тайлбарлах (харьцуулсан, шалтгаан болон үр дүн, 	<ol style="list-style-type: none"> 1. Д.Дэнсмаа “Мал жаргаах ухаан” 2. Ш.Цэрэнпил “Хэнээт” 3. Д.Батбаяр “Үнэлэх” 4. Л.Хэрлэнтуяа “Нэр төр” (хэсгээс) 5. Д.Батбаяр “Өс өвөрлөх” 6. Л.Түдэв “Нэр” (хэсгээс) 7. Д.Батбаяр “Үг” 8. Л.Түдэв “Дулаарлын айдас” 9. Л. Түдэв “Гүйдэл” 10. Л.Түдэв “Хурд нэмэх жам” 11. М.Монтень “Нэг л үр дүнд янз бүрийн аргаар хүрч болдог” 12. Л.Түдэв “Хувь хүний засгийн газар” 13. Л.Түдэв” Газрын юм” 14. Б.Ринчен “Номын садан” 15. Л.Түдэв “Эргүүлгийн тухай эргэцүүлэл” 16. Л.Түдэв “Оюуны лус”

	<p>асуудал болон шийдэл, цаг хугацааны дараалал гэх мэт) Тухайлбал: Тайлбарлаж уншихдаа төлөвлөгөөний аргыг хэрэглэж болно. Уншиж тэмдэглэл хийж сурахад чиглэсэн хэд хэдэн үе шатаар хэрэгжих арга бөгөөд сурагчид уншихын өмнө эсвэл унших явцдаа бодож тэмдэглэж уншина.</p> <ol style="list-style-type: none"> 1. Уншихын өмнө эх бичвэрийн агуулгыг таамаглах тэмдэглэл хөтлөх 2. Мэддэг болон мэддэггүйгээр ялгаж тэмдэглэж унших 	<ol style="list-style-type: none"> 17. Д.Батбаяр “Нууцын нууц” 18. Ч.Эрдэнэ “Хас ба хос” 19. Л.Түдэв “Үхэр хулгана –харх” 20. Д.Батбаяр “Мөс” 21. Л.Түдэв “Дэлгэцийн дээрэмчин” 22. Д.Нямаа “Мэргэний хөндийд дөрвөн цаг эгшиглэнэ” 23. Л.Түдэв “Өргөс”
<p>10.1в. Тайлбарласан эсээний зохиогчийн ашигласан баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийх</p>	<p>Зохиогчийн ашигласан баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийхийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Баримт нь найдвартай эх сурвалжаас авсан эсэх, хувь хүний туршлага болон сорил туршилтаар батлагдсан эсэхийг ажиглах - Тийм, үгүй гэдэгт тайлбар хийж ярилцах - Баримт мэдээллийг баяжуулах, нэмэх, ханын үзүүлэн бэлтгэх гэх мэтээр сурагчид хичээлийн бус цагаар төрөл бүрийн мэдээлэл цуглуулан сэдэв агуулгаар, зохиомол зохиомол бусаар нь, цаг хугацааны дарааллаар нь, сонирхолтой сонирхолгүйгээр нь гэх мэтээр ангилан ялгах - Тэдгээрийг эрэмбэлэн ялгаснаа компьютерээр бичиж багшдаа шалгуулах. Жишээ нь: Гиннесийн ном, улаан номоос маш сонирхолтой олон баримтуудыг цуглуулж бусад өөр төрлийн баримтуудтай харьцуулан ангилах даалгавар гүйцэтгэж болно. - Цаашлаад, баримт мэдээлэл зохиомол уу, зохиомол бус уу гэдэг дээр үндэслэн эх бичвэрийн найдвартай эх сурвалжид үндэслэсэн эсэх талаар асуудал дэвшүүлэн хэлэлцүүлэг өрнүүлэх. Жишээ нь: “Хүн анхандаа амаараа биш, хамраараа ярьдаг байжээ.” (Л.Т) гэх мэт сонирхол татсан баримт мэдээллүүдэд үе үе дүгнэлт хийж ярилцана гэсэн үг. “Орчин үеийн эх сурвалж, өнгөрсөн үеийн эх сурвалж хоёрын аль нь илүү найдвартай байж болох вэ?, Нэг ижил сэдвээр хүүхдэд зориулсан бүтээл бичих, мэргэжлийн ном бүтээх хоёрын аль нь найдваргүй байж болох вэ? Яагаад?, Ямар нэг баримтыг сонин хэвлэлд ашиглах, мэргэжлийн сэтгүүлд ашиглах хоёр ялгаатай байх уу? адил байх уу? гэх мэтээр хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлэх - Баримт мэдээллийг маш олон талаас, олон янзаар ажиглаж төрөл бүрийн дүгнэлт хийж сурсны дараа эцэст нь эсээ бичвэр, хөрөг найруулал гэх мэт бичвэрийн төрөл дээр анализ хийх 	<ol style="list-style-type: none"> 1. Д.Дэнсмаа “Мал жаргаах ухаан” 2. Ш.Цэрэнпил “Хэнээт” 3. Д.Батбаяр “Үнэлэх” 4. Л.Хэрлэнтуяа “Нэр төр” (хэсгээс) 5. Д.Батбаяр “Өс өвөрлөх” 6. Л.Түдэв “Нэр” (хэсгээс) 7. Д.Батбаяр “Үг” 8. Л.Түдэв “Дулаарлын айдас” 9. Л.Түдэв “Гүйдэл” 10. Л.Түдэв “Хурд нэмэх жам” 11. М.Монтень “Нэг л үр дүнд янз бүрийн аргаар хүрч болдог” 12. Л.Түдэв “Хувь хүний засгийн газар”

	<ul style="list-style-type: none"> - Эсээг өгүүлэгчийн үзэл бодол, баримт гэсэн хэсэгт ялгаж унших - Эсээнд өгүүлэгч дэвшүүлсэн асуудлаа дэмжсэн мэдээллээр баяжуулж чадсан, эсэхэд сурагчид дүгнэлт өгч, улмаар өөрөө эсээ бичихдээ баримтыг хэрхэн ашиглахаа сонгох <p>Багшид зөвлөх нь: Зохиогчийн ашигласан баримтад дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах чадварын эцсийн үр дүн нь үзэл бодол ба баримт хосолсон эхийн жишээн дээр ажиллаж үнэлгээ хийх юм. Ийм төрлийн бичвэр нь голдуу эсээ байдаг. Эсээнд дэвшүүлсэн үзэл бодлоо нотлох баримтад дүн шинжилгээ хийнэ гэсэн үг. Энэ нь эсээнд өөрийн дэвшүүлсэн асуудлаа нотолж батлахын тулд сонирхолтой баримт ашиглах уу, аль эсвэл найдвартай баримт ашиглах уу гэдэг сонголтоо зөв хийхэд чиглэсэн ажил гэдгийг анхаарна. Сурагчид төрөл бүрийн баримт мэдээлэлд үнэлгээ, шинжилгээ хийнэ. Юуны түрүүн яаран томоохон эх бичвэр, эсээ, шүүмж гэх мэт дээр шууд задлан шинжилгээ хийхээс татгалзвал сайн.</p> <ul style="list-style-type: none"> - Багш, сурагч хамтран сонирхол татах төрөл бүрийн баримт мэдээллийг уншиж хэлэлцэнэ. <p>Жнь: Багш, сурагчдаар уншуулсан мэдээлэл хэр үнэмшилтэй байгаа талаар ярилцаж болох юм. Түүний дараа тухайн мэдээллийг хэн гэдэг зохиолчийн, ямар нэртэй, хэдэн онд, ямар хэвлэлийн газарт хэвлүүлсэн номын хэддүгээр талаас авснаа юм уу эсвэл хэдний өдрийн, ямар сонин, сайтад ямар хүний бичсэн нийтлэлээс авснаа тайлбарлана. Учир нь найдвартай үнэн баримт бол юуны түрүүн эш татсан эх сурвалж нь үнэн байх ёстой гэдгийг ойлгуулах нь ач холбогдолтой гэсэн үг. Эндээс сурагчид ашиглаж байгаа мэдээлэл ном, хэвлэлийн адил найдвартай байх ёстой гэдэг зарчмыг өөртөө суулгаж авах ёстой.</p>	<ol style="list-style-type: none"> 13. Л.Түдэв” Газрын юм” 14. Б.Ринчен “Номын садан” 15. Л.Түдэв “Эргүүлгийн тухай эргэцүүлэл” 16. Л.Түдэв “Оюуны лус” 17. Д.Батбаяр “Нууцын нууц” 18. Ч.Эрдэнэ “Хас ба хос” 19. Л.Түдэв “Үхэр хулгана –харх” 20. Д.Батбаяр “Мөс” 21. Л.Түдэв “Дэлгэцийн дээрэмчин” 22. Д.Нямаа “Мэргэний хөндийд дөрвөн цаг эгшиглэнэ” 23. Л.Түдэв “Өргөс”
<p>10.1г. Хөрөг найруулал, тайлбарласан эсээнд зохиогчийн үг сонгосон (уран дүрслэл, хэлц) шалтгааныг тайлбарлах</p>	<ul style="list-style-type: none"> - Эхээс уран дүрслэл бүхий үгсийг ялгаж тэмдэглэх - Хэнийг / Юуг (дүр, хэрэг явдал, зан төрх, зөрчил тэмцэл, үг яриа, үйлдэл...) уран дүрслэлийн ямар аргаар дүрсэлсэн байгааг тодорхойлох - Аль шинжийг нь товойлгон дүрсэлснийг тайлбарлах - Яагаад ингэж товойлгон дүрсэлсний шалтгааныг тайлбарлах - Уран дүрслэлийг хэрэглэснээрээ эхийн утга агуулгад ямар өөрчлөлт гарч байгааг ярилцах - Бичигчийн хэрэглэсэн уран дүрслэлүүдийг утга, ур маяг тус бүрээр нэгтгэж үзвэл хэний ямар санаа, үзэл хандлага илэрч байгааг дүгнэх - Ямар гүн утгыг шингээх зорилгоор ашигласныг тайлбарлах - Хэний /өгүүлэгчийн, дүрийн/ ярианд илэрч байгааг илрүүлэх - Юуг / дүрийн зан чанар, соёл, ёс суртахуун, хувийн онцлог, араншин, нийгмийн байр суурь, үйлийн явц, эрчим.../ тодруулах үүрэгтэй орсныг батлах 	<ol style="list-style-type: none"> 1. Д.Дэнсмаа “Мал жаргаах ухаан” 2. Ш.Цэрэнпил “Хэнээт” 3. Д.Батбаяр “Үнэлэх” 4. Л.Хэрлэнтуяа “Нэр төр” (хэсгээс) 5. Д.Батбаяр “Өс өвөрлөх” 6. Л.Түдэв “Нэр” (хэсгээс) 7. Д.Батбаяр “Үг” 8. Л.Түдэв “Дулаарлын айдас”

	<ul style="list-style-type: none"> - Хэний ямар өнгө аяс, хандлагыг илтгэсэн байгааг батлах - Өвөрмөц ба хэвшмэл хэлц / зүйр үг, цэцэн үг, оноч үг, ёгт үг, шог яриа, дүрслэг үг, мэргэн үг, оньсого .../ -ийг ялгаж, хэрэглэсэн зорилгыг тайлбарлах - Уран дүрслэлийн ямар аргаар бүтсэнийг тайлбарлах - Хэлцийг ашигласнаараа санааг хэрхэн тодорхой, уран болгож байгааг дүгнэх <p>Багшид зөвлөх нь: Уран дүрслэл, хэлц нь эхэд дүрийн аль нэг шинж болон хэрэг явдал, мэдэгдэхгүй байгаа юм, үзэгдлийг уншигчдад ойлгуулахын тулд ижил төстэй шинжээр нь жишин таниулдаг нэг арга юм. Тиймээс дүрслэлээр дамжин илрэх энгийн утгаас үзэгдэл, юмсын гүн утга руу шилжилт хийх шаардлага уншигчдын өмнө тулгардаг. Мөн зохиолчоос уншигчийг төөрөгдүүлэх, зохиолын утгын тайллыг нууцлах зэрэг уран сайхны тодорхой шалтгаан зорилгоор эсвэл үйл явдлын өрнөлийг сонирхолтой ээдрээтэй болгох зорилгоор ч уран дүрслэлийг ашигладаг.</p> <p>Дээрх үйл ажиллагааны алхам, дарааллаар үйл ажиллагааг удирдах ба хамгийн гол нь ямар утгыг, ямар үгээр хэрхэн илэрхийлсэн байна? Ингэснээрээ утга хэр гүн гүнзгий болж байна? Энэ нь ямар зорилготой байж болох талаар эхийн утгын хүрээнд ярилцаж, уран дүрслэл, хэлц, албаны үг хэллэгийн эхэд гүйцэтгэх үүргийг ойлгуулахад анхаарна. Учир нь бүтээлчээр бичих үйл ажиллагааны явцад сурагчид эдгээр үг хэллэгийг идэвхтэй хэрэглэх юм. Ингэж хэрэглүүлэхийн тулд бичих үйл ажилагааны урьтал болгож, түүсэн үг хэллэгээр өгүүлбэр зохиох, эх зохиох, өөр үг хэллэгээр солин найруулах, утгыг шууд утгатай болгон найруулах, шууд утгатай үг хэллэгийг хэлцээр солин найруулах, үүсгэл санаа ба уран дүрслэлийг тайлбарлах, өгүүлбэр цогцолборын санааг хэлцээр хураах, өвөрмөц хэлц, онч үгс, цэцэн үг, зүйр үг, оньсогын санааг задлан тайлбарлах, тайлбарламж эх зохиох, эхийн доторх зарим үзэгдэл юмсыг уран дүрслэлтэй болгож дэлгэрүүлэн бичих зэргээр үйл ажиллагаагаа өргөжүүлж болно.</p> <p>Мөн энэ үед уран дүрслэлийн арга болон хэлцийн талаар онолын ойлголт өгнө.</p>	<ol style="list-style-type: none"> 9. Л. Түдэв “Гүйдэл” 10. Л.Түдэв “Хурд нэмэх жам” 11. М.Монтень “Нэг л үр дүнд янз бүрийн аргаар хүрч болдог” 12. Л.Түдэв “Хувь хүний засгийн газар” 13. Л.Түдэв” Газрын юм” 14. Б.Ринчен “Номын садан” 15. Л.Түдэв “Эргүүлгийн тухай эргэцүүлэл” 16. Л.Түдэв “Оюуны лус” 17. Д.Батбаяр “Нууцын нууц” 18. Ч.Эрдэнэ “Хас ба хос” 19. Л.Түдэв “Үхэр хулгана –харх” 20. Д.Батбаяр “Мөс” 21. Л.Түдэв “Дэлгэцийн дээрэмчин” 22. Д.Нямаа “Мэргэний хөндийд дөрвөн цаг эгшиглэнэ” 23. Л.Түдэв “Өргөс”
<p>10.1д. Ажлын удирдамж, тайланд албаны үг хэллэг хэрэглэсэн зорилгыг тайлбарлах</p>	<ul style="list-style-type: none"> - Албан бичгийн найруулга болон уран зохиолын найруулга бүхий эхийг унших явцдаа албан үг хэллэгийн доогуур зурж тэмдэглэх - Уг үг хэллэгийг хэн хэлж байгааг тодорхойлох - Энэ нь тухайн найруулгын төрөлтэй холбоотой юу? Эсвэл тухайн дүрийг тодруулах үүрэгтэй орж байна уу? гэдгийг батлан тайлбарлах - Албаны үг хэллэгийг ямар тохиолдолд хэрэглэж болдгийг дүгнэх 	<ul style="list-style-type: none"> - Ажлын удирдамж - Тайлан

	<ul style="list-style-type: none"> - Албаны үг хэллэгт ямар ямар үгийн сангийн үг хамаардгийг ойлгох • Хүндэтгэлийн үг • Нэр томьёо • Мэргэжлийн үг • Нийтээр хэрэглэдэг гадаад үг 	
<p>10.1е. Тайлбарласан эсээнд хэрэглэсэн харьцуулсан утгатай бүтээвэр, холбох (зэрэгцүүлэх, угсруулах) үгийг олж, шалтгааныг тайлбарлах</p>	<ul style="list-style-type: none"> - Эхийг бүхэлд нь ерөнхий дүр зургийг гаргаж унших - Эсрэг ба ойролцоо утгат нийлмэл өгүүлбэрийн холбох хэрэглүүр (аялга, нөхцөл, холбох үг) - ийн утга (эсрэгцүүлэх, харшуулах г.м.) ба үүргийг тодорхойлох - Нийлмэл өгүүлбэрүүдийг энгийн өгүүлбэрээр зааглаж ойлгохоос гадна төрөл бүрийн харьцуулсан утгатай өгүүлбэр, цогцолборуудад харьцуулсан утгыг яаж, ямар аргаар илэрхийлсэн арга замыг судлах - Энгийн өгүүлбэрүүдийг ямар хэрэглүүрээр холбосныг нэрлэх, ангилах, тодорхойлох (аялгаар, нөхцөлөөр, холбох үгээр, төлөөний үгээр, үндсээр, “гэ”язгуурт үйл үгээр), эдгээрийн дотроос харьцуулсан утгат холбоосын утгын ялгааг олж тайлбарлах - Цаашлаад өгүүлбэрээс дээш түвшний нэгж болох цогцолборын түвшинд ажиглалт хийж, тайлбарлах. - Агуулгын бүтцээр задлан шинжлэх. Цогцолбор хоорондын утгын уялдаа холбоог тогтоох. - Юмс үзэгдлийг харьцуулж буй аргыг тодорхойлох - Харьцуулахад хэрэглэсэн үг хэллэг, өгүүлбэрүүдэд задлан шинжилгээ хийхдээ харьцуулсан утгат холбоосууд нь эхэнд өгүүлсэн мэдээллийг өөр зүйлтэй харьцуулж утгыг лавшруулахад чухал үүрэгтэй байдгийг тодруулах <p>Багшид зөвлөх нь: Харьцуулж бичихэд угсруулах ба зэрэгцүүлэх утгат бүтээвэр холбох үгийн үүргийг тайлбарлахын тулд төрөл бүрийн холбоосыг ажиглаж, утгаар ангилан ялгадаг байх нь чухал. Жишээ нь: “- сан + аас гадна, - ний дээр + бас, - сан + аас өөр, бусад, - х + ын зэрэгцээгээр, сацуу” гэх мэт нийлмэл өгүүлбэрийг өгүүлбэрийг холбох дотоод холбоос, “гэхийн зэрэгцээ, гэдгийн хажуугаар, түүнээс гадна, үүний дээрээс, бас, үүний хувьд, түүний дотроос, үүний зэрэгцээгээр, ингэсний хамт, үүний сацуу, гэтэл, харин, атал, ба, бөгөөд, хийгээд, буюу, мөн түүнчлэн, эсвэл, тэгэвч, аль эсхүл, эсвэл, нөгөөтэйгүүр, нөгөө талаар” гэх мэт өгүүлбэр ба цогцолборыг холбох гадаад холбоосуудын утга үүргийг ойлгох, тайлбарлах чадвартай болно. Харьцуулан тайлбарласан эсээг бичихийн өмнө “Хоёр “Plus” – ын алинд нь “нэмэх” тавих вэ?” гэсэн харьцуулсан тайлбарыг үлгэр болгож уншаад, багцлах ба хэсэглэх аргын тайлбарыг ажиглаж анализ хийж болох юм. Сурагчид аливаа эхийг бүтээж байгаа үгсийн утгыг мэдэж байгаа боловч үг ба өгүүлбэрийг холбож буй холбоосыг ойлгоогүйгээс шалтгаалан эхийг бүрэн дүүрэн ойлгож чаддаггүй. Энэ чадварыг хөгжүүлэхийн тулд:</p>	<ol style="list-style-type: none"> 1. Д.Дэнсмаа “Мал жаргаах ухаан” 2. Ш.Цэрэнпил “Хэнээт” 3. Д.Батбаяр “Үнэлэх” 4. Л.Хэрлэнтуяа “Нэр төр” (хэсгээс) 5. Д.Батбаяр “Өс өвөрлөх” 6. Л.Түдэв “Нэр” (хэсгээс) 7. Д.Батбаяр “Үг” 8. Л.Түдэв “Дулаарлын айдас” 9. Л. Түдэв “Гүйдэл” 10. Л.Түдэв “Хурд нэмэх жам” 11. М.Монтень “Нэг л үр дүнд янз бүрийн аргаар хүрч болдог” 12. Л.Түдэв “Хувь хүний засгийн газар” 13. Л.Түдэв “Газрын юм” 14. Б.Ринчен “Номын садан” 15. Л.Түдэв “Эргүүлгийн тухай эргэцүүлэл” 16. Л.Түдэв “Оюуны лус” 17. Д.Батбаяр “Нууцын нууц” 18. Ч.Эрдэнэ “Хас ба хос”

	<p>Харьцуулан тайлбарласан төрөл бүрийн эхэд задлал хийх аргачлал: Дадлага ажлын эхэнд нийт сурагчид бие даан эхийг судлах ба дараа нь багшийн удирдлага дор багаар эсвэл бие дааж ажиллана.</p> <p>Харьцуулан жишиж бичих аргыг ихэвчлэн тайлбарласан эсээг бичихэд хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл нэг зүйлийг нөгөөтэй харьцуулж тайлбарласан харьцуулал байна гэсэн үг. Хоёр сэдвийн ижил ба ялгаатай талыг жишиж, харьцуулж бичдэг. Өгүүлж буй юм, үйл явдлын тухай харьцуулж жиших замаар эсээнийхээ ерөнхий дүр зургийг гаргана. Эсээний ерөнхий дүр зураг сайн, муу болох нь юуг харьцуулахаас шалтгаалдаг. Энэ нь ямар мэдээллүүд тухайн эсээнд байх вэ? гэдгийг шийддэг. Харьцуулан жишиж тайлбарлахын өмнө ямар дэс дарааллаар хийх аргаа сонгоно. Харьцууллыг хоёр аргаар хийж болно.</p> <ol style="list-style-type: none"> 1. Бичиж буй сэдвийнхээ хүрээн дэх бүхий л зүйлийг харьцуулах: Үүнийг ерөнхийд нь харьцуулах гэнэ. Зарим зохиогч харьцуулах ба жиших аргыг бичигт хэрэглэхдээ сонгосон сэдвийнхээ хүрээн дэх бүхий л асуудлыг хөнддөг. Энэ аргыг хэрэглэх нь, зохиолч нь сэдвийн эргэн тойронд буй бүх нарийн ширийн зүйлийг судлах, шинжлэх шаардлагатай болдог. Тэгээд бүхэлд нь харьцуулан жишдэг. 2. Аль нэгэн онцлог шинжийг сонгон бичиж тайлбарлах: Ингэж бичихдээ сэдвийн хүрээн дэх ойлголтуудаас аль нэг онцлог шинжийг сонгоод нөгөө сэдвийн өөр нэгэн онцлогтой харьцуулж тайлбарладаг. Тухайлбал: Дүрслэх, дараалах, харьцуулахын аль нь ч байсан дараах холбоосуудыг хэрэглэдэг. Үүнд: Ялгаатай нь, байдаг бол г.м. Жишээлбэл: “Бабаар хааны хүү Хумаан шинжлэхүй ухааныг ихэд тэтгэн хөгжүүлсэн гүн, ухаантай, одон орон судлаач, математикч бас маш сайн зураач байсан бол гурав дахь хаан Акбар улсын газрыг өргөтгөн шинэ гүрний улс төрийн тогтолцоог бүрдүүлж, шашны тэгш эрхийг зарлан тунхаглажээ.” (Б.Н) ¹ хэмээн харьцуулсан тайлбар хийхэд “бол” гэсэн холбоос үг чухал үүрэгтэй байна. Харьцуулан жишиж тайлбарласан эсээний зорилго нь харьцуулж буй асуудлын адил ба өөр талыг олон талаас нь харж гаргаж ирэхэд оршино. 	<p>19. Л.Түдэв “Үхэр хулгана –харх”</p> <p>20. Д.Батбаяр “Мөс”</p> <p>21. Л.Түдэв “Дэлгэцийн дээрэмчин”</p> <p>22. Д.Нямаа “Мэргэний хөндийд дөрвөн цаг эгшиглэнэ”</p> <p>23. Л.Түдэв “Өргөс”</p>
<p>10.1ж. Албан бичгийн эхийн зэрэгцүүлэн тоочсон өгүүлбэр, цэг тэмдгийн хэрэглээг тодорхойлж, үүргийг тайлбарлах</p>	<ul style="list-style-type: none"> - Зэрэгцүүлэн тоочсон өгүүлбэрт цуваа цэг, цэгтэй таслалыг зөв хэрэглэх - Таслалыг зөв хэрэглэх, буруу хэрэглэснээс үүдэн өгүүлбэрийн утга алдагдахыг ойлгох - Анхааруулах, захирах өгүүлбэрт цэг тэмдгийг хэрэглэх 	<ul style="list-style-type: none"> - Ажлын удирдамж - Тайлан

¹ Энэтхэгийн түүхэнд тодорсон агуу хаадын тоонд Их Монголын Бабаар хийгээд түүний ач хүү Акбар нар зүй ёсоор ордог.” Б.Номинчимэд “Өдрийн сонин”

	<ul style="list-style-type: none"> - Таслал, хаалт, хашилт болон бусад цэг тэмдгийг тохируулж хэрэглэх - Тоочих өгүүлбэрийг компьютерийн төрөл бүрийн программд оруулж бичихэд цэг тэмдгийг зөв хэрэглэх - Алдаагаа хянах, сийрүүлэх, залруулах 	
--	--	--

БИЧИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.2а. Олон ургальч үзэл бодлыг харьцуулж, асуудал дэвшүүлэн тайлбарлан бичих</p>	<ul style="list-style-type: none"> - Эхийг уншиж бичил судалгаа хийх - Өгүүлбэрүүдийн адил ба ялгаатай бичлэгийн хэлбэрт анализ хийх - Хоёр ба түүнээс дээш хэд хэдэн ялгаатай үг хэллэг бүхий өгүүлбэрийг харьцуулан дүгнэх - Дүгнэлт бичихийн тулд төрөл бүрийн харьцуулан жиших холбоосуудыг хэрэглэж бичих дадлага хийх - Нэг агуулгын дор бичсэн өөр өөр зохиолчдын бүтээлүүдээс сонгон авч уншиж судалсны үндсэн дээр бичих - Эхийг бичсэн цаг үеийн амьдралыг судлан жишээ баримтаар нотлох - Харьцууллыг венийн диаграммын аргаар хийх - Эхийн доторх аль нэг хэсгийг сонгон харьцуулах дадлага хийх. Тухайлбал: Өнгөрсөн ба өнөөгийн сургуулийн амьдралыг харьцуулан бичих - Харьцуулан бичихдээ, үндэслэл нотолгоотой хандахын тулд судалсан эхүүдээс жишээ татаж бичих, баримтаар баталж бичих - Харьцууллыг өвөрмөц содон, сонирхол татахуйц хөтөч санаагаар эхэлж бичих <p>Багшид зөвлөх нь: Асуудал дэвшүүлэн ялгаатай үзэл бодлыг харьцуулж тайлбарлан бичихийн тулд асуудлаа оновчтой дэвшүүлж сурахад анхаарлаа хандуулж ажиллана. Энэ чадвар нь угтаа харьцуулан тайлбарласан эсээ бичих чадварт сургана гэсэн үг. Ингэж бичих явцдаа сурагчид юу, юу хийж сурав? гэдэг нь хамгийн чухал. Жишээлбэл: “Анхны сурагчид, өнөөгийн сурагчдыг харьцуулан тайлбарлах нь” сэдвийн дор харьцуулан тайлбарласан эсээ бичихийн тулд бичил судалгааг хийж, гүйцэтгэнэ.</p> <p>Монголд анхны сургууль байгуулагдах үеийн сурагчид, сургуулийн амьдрал, өнөөдрийн сурагчид, сургуулийн амьдралын ялгааг харьцуулан тайлбарласан эсээ бичнэ. Үүний тулд: Хоёр зүйлийн нэгийг нөгөөтэй харьцуулж тайлбарласан харьцуулал байна. Юу, юуг харьцуулах вэ? гэдгээ сонгох юм. Хоёр асуудлын ижил ба ялгаатай талыг жишиж, харьцуулахын тулд тухайн цаг үеийн хүүхдүүдийн онцлогийг судлах шаардлагатай болно. Энэ судалгааг тухайн үеийн сурагчдын болон</p>	<ul style="list-style-type: none"> - Тайлбарласан эсээ, - Хөрөг найруулал - Төрөл бүрийн эхийн загвар - Сурагчийн бичсэн эхүүд

	<p>сургуулийн амьдралыг бичиж туурвисан зарим ном зохиолоос сонгон эрэл хайгуул хийж болно. Тухайлбал: Ч.Лодойдамба “Манай сургуулийнхан” тууж (1952), Д.Цэвэгмэд “Сурагч Ганбат” тууж (1940), П.Лувсанцэрэн “Усны эргүүлэг буюу борзооны явдал” (1972) гэх мэт. Гаргасан санаагаа өөрийн үзэл бодол, шалтгаан, жишээ баримтуудаар баяжуулж бичнэ.</p>	
<p>10.26. Загварт найруулгын бүтэц онцлог, агуулгын уялдаа холбоог гаргаж тоочин бичих</p>	<p>Тогтсон бүтэц, дараалал, утгын уялдаа холбоог гаргаж тоочин бичихийн тулд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Уншиж судалсан баримт бичгүүдийнхээ онцлог, утга, бүтэц, загварыг сэргээн санах дасгалуудыг ажиллах 2. Ямар утгатай, ямар албан бичиг бичихээ сонгох 3. Бичих сэдвээ сонгох 4. Албан бичгийн тогтсон стандарт загварын дагуу бичих 5. Бичих зүйлийнхээ төлөвлөгөөг хийхдээ утгын уялдаа холбоог дараах байдлаас сонгон гаргаж болно. <ul style="list-style-type: none"> ○ Цаг хугацаагаар ○ Орон байраар ○ Шалтгаан-үрээр ○ Асуудал-шийдэл гэх мэтээр байрлуулах 6. Ноороглохдоо дараах зүйлийг анхаарч бичнэ. <ul style="list-style-type: none"> ○ Өгүүлбэрийн хэв шинжээ зөв сонгоно. Сонгосон өгүүлбэр тань тоочсон байна уу? гэдгийг шалга. ○ Өгүүлбэрийн төгсгөлөө зөв гаргана. Тоочсон тохиолдолд өгүүлбэрийн төгсгөл ихэвчлэн нэг төрлийн байдгийг санах ○ Өгүүлбэрийн гишүүд нь үндсэн байрандаа байх ○ Нэг төрлийн утгын айд хамаарах үгийг сонгож, тоочсон хэв маягаа гаргах <p>Цэг тэмдгийг зөв хэрэглэх</p> <p>Багшид зөвлөх нь: <i>Загварт найруулгын бүтэц, онцлог, утгын уялдаа холбоог гаргаж тоочин бичих</i></p> <p>Албан харилцааны үүрэг гүйцэтгэж байгаа баримт бичиг (зарлиг, тогтоол, тушаал, захирамж, албан даалгавар, ажлын удирдамж, хурлын тэмдэглэл, тайлан, илтгэх хуудас г.м) –ийн хэл найруулгыг албан бичгийн найруулга гэнэ. Албан бичиг нь эртний уламжлалтай учир зарим эртний дурсгал бичгүүдийн бүтэц, хэл найруулга, бичлэгийн хэлбэр зэргийг харьцуулан, хэрхэн өөрчлөгдөж, хөгжиж ирснийг таниулж болох юм. Гэхдээ 10-р ангид заавал судлах цаг бага учир үүнийг бие даан судлуулж, илтгэл, реферат бичих зэргээр багаар, хосоор ажиллуулан бие даах цагийн үнэлгээнд тооцож болох юм.</p> <p>Албан бичгийг заавал тогтсон загварын дагуу бичүүлж сургахад анхаарна. Эрт цагт албан бичгийг буруу үйлдсэн бол донгодох, торгох, сануулга өгөх, занчих</p>	<ul style="list-style-type: none"> - Ажлын удирдамж - Тайлан

	<p>зэргээр шийтгэдэг байсан байна. Энэ нь албан харилцааны учир ажээ.</p> <p>Албан бичгийн найруулга нь тогтсон стандарт загвартай, утга санаа ойлгомжтой, юм, үзэгдэл, хэрэг явдлыг бодитой тодорхой дүрслэн бичих, утга агуулга товч байх, элдэв уран, хоёрдмол санаа агуулаагүй байх, бичигчийн сэтгэл хөдлөл илрээгүй байх зэрэг онцлогтой. Тиймээс энэ бичвэрийг уншиж, судлах явцдаа онцлогийг танин мэдүүлэх ба бүтээлчээр бичиж эхлэхээс өмнө дараах үйл ажиллагаануудыг хийгээрэй.</p> <ul style="list-style-type: none"> • Алдаатай албан бичгийг стандартад тохируулан загвар, хэл найруулга, хэлбэр, утга, бүтцийг засан сайжруулах • Загварт тохируулан албан бичиг бичих • Орхисон бүрдэл хэсгүүдийг нөхөж зөв болгох • Бичвэрийн уялдаа холбоог сайжруулах • Үг, өгүүлбэрийн хэлбэржилт тоочсон байгаа эсэхийг хянаж, сайжруулах • Тэргүү болон баримт бичгийн нэрийг бичилгүй орхисон загварыг хараад ямар баримт бичиг болохыг ялган таних, гүйцээх зэргээр ажиллаад үзээрэй. <p>Эдгээр дасгал ажлыг хийж гүйцэтгэсний дараа бүтээлчээр бичих үйл ажиллагаа руу шилжинэ. 10-р ангийн заавал судлахын хөтөлбөрт албан бичгүүдээс ажлын удирдамж, тайланг уншиж судлахаар заасан байгаа. Гэхдээ албан бичгийн найруулгын төрлөөр бичигдсэн олон олон баримт бичгийг бичих шаардлага хүн бүхний өмнө тулгардаг. Тиймээс хүн бүхний амьдралд хэрэгтэй гэсэн баримт бичгүүдийг багш өөрөө гаргаад, тэдгээрийг бичүүлж сургахад анхаараарай. Ийм замаар сурагчдын албан бичгийн талаарх мэдлэгийг гүнзгийрүүлээрэй. Албан баримт бичгүүдийн талаарх мэдлэгийг бататгах, тэднийг бичиж сурах үйлийг хөтлөхдөө:</p> <ul style="list-style-type: none"> ○ Хувийн туршлага дээр нь тулгуурлан бичих ○ Төсөөлөл дээр нь тулгуурлан бичих зэргээр ажиллаарай. <p>Жишээ нь: Хувийн туршлага дээр нь тулгуурлан бичүүлэх гэж байгаа бол: Чамд ямар баримт бичиг бичих шаардлага хамгийн их тулгарч байсан бэ? Чи түүнийг яаж бичиж байсан? гэх мэтээр өмнөх ойлголт, мэдлэгтэй нь холбон чиглүүлж болно.</p> <p>Харин төсөөлөл дээр нь тулгуурлан бичүүлэх гэж байгаа бол тодорхой чиглүүлэх асуултын дагуу бичүүлж болно. Жишээ нь: Чи өөрийгөө ... мэргэжилтэн/зөвлөх гэж төсөөл. Тэгээд хөдөөний нэгэн сумын ... албан газрын ажлыг сайжруулахаар тэнд ... хугацаатай ажиллажээ. Тэр хугацаанд хийх ажлын удирдамж болон хийсэн ажлынхаа тайланг бичнэ үү. Бичихдээ:</p> <ul style="list-style-type: none"> • Очиход тань нөхцөл байдал ямар байсан? 	
--	--	--

	<ul style="list-style-type: none"> • Та нөхцөл байдалтай танилцаад ямар төлөвлөгөө хийв? • Төлөвлөгөөний дагуу хэрхэн ажиллав? • Ямар үр дүнд хүрэв? гэх мэт 	
<p>10.2в. Мэдрэмж, сэтгэгдэл, үнэлэмжээ баримтад тулгуурлан дүрслэн бичих</p>	<p>Баримтад үндэслэн дүрслэн бичихдээ мэдрэмж, сэтгэгдлээ оруулан бичихийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Тайлбарлан дүрсэлж бичсэн эх дээр задлал хийж, тайлбар хэрхэн хийсэн талаарх мэдлэгээ сэргээн санах - Бичих сэдвээ сонгох - Бичихдээ аль аргыг сонгон бичихээ шийдэх - Хувийн туршлага дээрээ тулгуурлан дүрслэн бичих - Төсөөлөл дээрээ тулгуурлан дүрслэн бичих - Хийсвэр санаан дээр тулгуурлан дүрслэн бичих - Бичих төлөвлөгөө гаргахдаа түлхүүр өгүүлбэрээр илэрхийлэх - Уншиж, судалсан материалаасаа тухайн түлхүүр өгүүлбэрийн санааг бүрэн илэрхийлэх баримтыг сонгож, байрлуулах - Тухайн сонгосон баримтаас ямар үзэл бодол, сэтгэгдэл, мэдрэмж төрж байгаагаа тэмдэглэх - Ноороглон бичих - Засаж сайжруулах - Үнэлгээ өгөх <p>Багшид зөвлөх нь: Мэдрэмж нь харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх 5 мэдрэхүйгээр дамжин илрэх онцгой чадвар бөгөөд зарим зүйлд хариу үйлдэл үзүүлэх, түүнийг таних, үнэлэх, ойлгох чадвар юм. Өөрөөр хэлбэл гадаад орчныг мэдрэлдээ хүлээн авах чанар юм. Сэтгэгдэл нь сэтгэсэн, сэтгэгдсэн юм буюу хүн, юм, үзэгдлийн талаар төрсөн бодол, санаа гэсэн бол үнэлэмж нь юмны зэрэг, чанар хирийг тогтоох ба илүү дүгнэлтийн шинжтэй юм байна. Энэ чадварыг эзэмшүүлсний эцсийн үр дүнд хүн, юм, үзэгдлийн гадаад дотоод шинжийг бичихдээ уншигчийн нүдэнд харагдаж, чихэнд сонсогдож, гарт баригдаж, биед мэдрэгдэхээр тов тодорхой бичүүлж сургахад оршино. Тиймээс энэ чадварыг эзэмшүүлэхийн тулд дүрслэн бичих төрөл бүрийн арга, хэрэглүүрийг бүтээлчээр хэрэглэхэд анхаарна.</p> <ul style="list-style-type: none"> • Тэмдэг нэр / ямар+ямар+ямар+ямар юу ? гэх мэтээр олон давхарлаж хэрэглэх тусам утга илүү тодорхой болдог/ • Үйл үг / үйл үгийг ерөнхий утгаар биш тодорхой утгаар нь хэрэглэнэ. Жишээ нь: чихээ хөдөлгөнө гэхээс илүү хулмайлгана, соотойлгоно, солбилзуулна, сортойлгоно гэх мэтээр тухайн орчин нөхцөлд яг ямар үйл хөдөлгөөн хийснийг бичнэ./ • Дүрслэх болон дуурайх үг / юмсын дуу чимээ, дүр байдлыг илүү тодорхой болгодог./ 	<ol style="list-style-type: none"> 1. Д.Дэнсмаа “Мал жаргаах ухаан” 2. Ш.Цэрэнпил “Хэнээт” 3. Д.Батбаяр “Үнэлэх” 4. Л.Хэрлэнтуяа “Нэр төр” (хэсгээс) 5. Д.Батбаяр “Өс өвөрлөх” 6. Л.Түдэв “Нэр” (хэсгээс) 7. Д.Батбаяр “Үг” 8. Л.Түдэв “Дулаарлын айдас” 9. Л. Түдэв “Гүйдэл” 10. Л.Түдэв “Хурд нэмэх жам” 11. М.Монтень “Нэг л үр дүнд янз бүрийн аргаар хүрч болдог” 12. Л.Түдэв “Хувь хүний засгийн газар” 13. Л.Түдэв “Газрын юм” 14. Б.Ринчен “Номын садан” 15. Л.Түдэв “Эргүүлгийн

	<ul style="list-style-type: none"> • Орон цагийн нэр / тухайн юмны орон, цагийг тодорхой болгодог./ • Тодотгол гишүүн өгүүлбэр буюу тодотгон холбох нөхцөл бүхий үйл үг / юм, үзэгдлийн шинжийг тодорхой болгодог/ • Уран дүрслэл / дүр байдал, орон байр, хэрэг явдлын учир шалтгааны тодруулах, гадаад, дотоод шинж байдал, амьдралын орчин ахуй, сэтгэл санааны дотоод далд байдал зэргийг нээх, сэтгэл хөдлөлийг буй болгоход гол үүрэгтэй/ • Хэлц /хэт нуршмаар том санааг хурааж гүн утга бүхий товч, уран санаатай болгодог/ <p>Дээрх арга хэрэглүүрийг бичих зүйлдээ хэр бүтээлч хэрэглэсэн байна? гэдгээр нь өөрөөр нь болон бусдаар үнэлгээ хийлгэж болно. Хэрэв эдгээр аргуудыг сайн хэрэглэж чадаагүй бол сайжруулах боломжийг олгох хэрэгтэй. Мэдрэмж, сэтгэгдэл, үнэлэмжээ тухайн баримтад тулгуурлан илэрхийлнэ. Энэ үед суралцагчдыг баримтыг унших явцдаа өөртөө юу бодогдож, сэтгэгдэж, мэдрэгдэж байгаагаа сайн анзаарч уншихыг зөвлөөрэй. Хүүхдүүд заримдаа баримттай ямар ч холбоогүй сэтгэгдэл, үзэл бодол, мэдрэмжийг илэрхийлээд байдаг. Тиймээс үүнийг зөв ойлгохын тулд баримт, үзэл бодол, үнэлэмж, сэтгэгдэл, мэдрэмжийн алиныг хэрэглэснийг унших явцдаа сайтар ялгах нь чухал.</p>	<p>тухай эргэцүүлэл”</p> <ol style="list-style-type: none"> 16. Л.Түдэв “Оюуны лус” 17. Д.Батбаяр “Нууцын нууц” 18. Ч.Эрдэнэ “Хас ба хос” 19. Л.Түдэв “Үхэр хулгана – харх” 20. Д.Батбаяр “Мөс” 21. Л.Түдэв “Дэлгэцийн дээрэмчин” 22. Д.Нямаа “Мэргэний хөндийд дөрвөн цаг эгшиглэнэ” 23. Л.Түдэв “Өргөс”
<p>10.2г. Эхийг хурааж, дэлгэрүүлж найруулан бичих</p>	<p>Эхийг дэлгэрүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Тулгуур үгийг үг ,холбоо үг, өгүүлбэрээр нэмэн дэлгэрүүлэх - Эхийн гол санааг тайлбарлан дэлгэрүүлэх - Эхийн цөм өгүүлбэрт дэлгэрүүлэгч гишүүд нэмж ,санааг өргөжүүлэх - Эхийг адилтгал зүйрлэл зэрэг хэлцээр баяжуулах <p>Эхийг хураах</p> <ul style="list-style-type: none"> - Тулгуур үгсийг олж,санааг хураан бичих - Эхийн санааг товчоор илэрхийлж бичих - Өгүүлбэрээр хураах - Хэлцээр хураах <p>Багшид зөвлөх нь: Эхийн доторх нэгжийг хасах, нэмэх, нэгжүүдийн байрыг солих , эхийн бүтэц дэх нэгжийг солих буюу сэлгэх, бичлэгийн хэлбэрийг өөрчлөхийг <u>эхийн хувиргал</u> гэнэ.</p> <p>Хөрөг эхийг дараах асуултаар хурааж, хөргийн үндсэн дүрслэлийг ялгаж болно. (Уншиж судалсан эхээс хамааран багш задлах асуултаа зохионо.)</p> <ul style="list-style-type: none"> ○ Гол дүрийг төлөөлсөн үгс: ○ Өмссөн зүүсэн хувцас, эдлэлийг тодорхойлсон үг хэллэгүүд ○ Гадаад шинж төрхийг илэрхийлсэн үг хэллэгүүд ○ Зан төрхийг тодорхойлсон үг хэллэгүүд ○ Унаа малаа эдэлж буйг өгүүлсэн хэсэг 	<p>- Тайлбарласан эсээ - Л.Түдэв “Өс өвөрлөх”, “Ус гүйдэл”, “Дулаарлын айдас”, “Хурд нэмэх жам”, “Номын садан”, “Үхэр хулгана- харх” эсээ - Төрөл бүрийн хөрөг найруулал</p>

	<p>.....</p> <ul style="list-style-type: none"> ○ Үзэл бодлын талаар ойлгосноо тэмдэглэх ○ Хөгшид түүнд хэрхэн хандаж үнэлдэг тухай ○ Түүний талаарх бусдын бодлыг хэрхэн гаргасан бэ ? ○ Хүүхэд хөгшидгүй түүнийг хүндлэхийн учир юу вэ? 	
--	--	--

СОНСОХ-ЯРИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.3а. Тодорхой асуудлаар зорилго, нөхцөл байдал, харилцагчийн онцлогт тохируулан ярих</p>	<ul style="list-style-type: none"> - Үйл явдал болж буй нөхцөл байдал нь тодорхой, уур амьсгал нь мэдрэгдэхүйц, хүмүүсийн сэтгэл хөдлөл нь тодорхой зурагнаас сонголт хийх - Зураг дээр ямар нөхцөл байдал бий болсныг тоочин самбарт бичих - Асуултад хариулж ярилцах. Жишээ нь: - Ямар үйл явдал хаана болж байна? - Энэ үйл явдлын зорилго юу байв? - Хүмүүсийн харилцаа, уур амьсгал ямар байна? Түүнийг яаж мэдэв? - Чи өөрийгөө уг үйл явдалд оролцож байгаа гол хүний нэг гэж өөрийгөө төсөөлөөд нөгөө хүнийхээ сэтгэл хөдлөлийг мэдэрч зөвлөгөө өгөх, дэмжих, ятгах, тайвшуурлах зэргээр ярих - Нөхцөл байдлыг эргүүлэн өөр нөхцөл байдлыг бий болгож, яриа өрнүүлэх - Ярианы зорилгыг өөрчлөн ярих <p>Харилцагчийг /хүүхэд, хөгшид, дээд албан тушаалтан гэх мэт/ өөрчлөн ярих</p>	<ul style="list-style-type: none"> - Хөрөг - Уран зураг - Асуудал дэвшүүлсэн илтгэл
<p>10.3б. Үзэл бодол, сэтгэгдэл, мэдрэмжээ жишээ баримт, эшлэл, уран дүрслэл, хэлц зэргийг ашиглан илэрхийлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Үндэслэлтэй, итгэл үнэмшилтэй, сонсогчийн сонирхлыг татаж ярьж илтгэх төрөл бүрийн аргыг турших - Эдгээрийг оновчтой ашиглах нь яриаг хөгжүүлэх үр дүнтэй арга болохыг ойлгох - Зөв сонгосон жишээ баримт, эшлэл, уран дүрслэл, хэлц нь өгүүлэгч сонсогчийг улам ойртуулдгийг мэдэхийн тулд <ul style="list-style-type: none"> ▪ Ярих сэдвийн агуулгыг сайтар ойлгосон байх ▪ Ярих сэдвийн агуулгад тохируулан тодорхой зорилготой, улиг домог болоогүй, нэг санааг давтсан шинжгүй жишээ баримт, эшлэл, уран дүрслэл, хэлцийг сонгож олох ▪ Эдгээр жишээ баримт, эшлэл, уран дүрслэл, хэлцийг яриандаа урьдаас нягтлан бодож оруулсан эсэхийг хянах, хэлэлцэх, үнэлэх <p>Багшид зөвлөх нь: Яриандаа жишээ баримт, эшлэл, уран дүрслэл, хэлцийг сонгож оруулахын өмнө дараах байдлаар нягтална.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Сонгосон жишээ баримт, эшлэл, уран дүрслэл, хэлц нь олон нийтийн санаанд нийцэх болов уу? ▪ Аль хэр гүн агуулгыг илэрхийлж чадах вэ? 	<ul style="list-style-type: none"> - Хөрөг - Уран зураг - Асуудал дэвшүүлсэн илтгэл - Төрөл бүрийн баримтын эх

	<ul style="list-style-type: none"> ▪ Эдгээр жишээ баримт, эшлэл, уран дүрслэл, хэлцийн утгыг нарийн нягталсан уу? Жишээ нь сонгосон эшлэл, жишээ, дүрслэл, хэлц гэх мэтийн утгыг нарийн нягтлахын тулд тайлбарлах үйлд тулгуурлаж болно. Хэлцийн хувьд аль болох монголчуудын уламжлалт аж ахуй, нүүдлийн соёл, сэтгэлгээний онцлогийг уул юманд хандаж буй хандлага, үнэлэмжтэй холбон, хэллэг бүрийн утга санааг өгүүлбэрт оруулан тодорхойлж тайлбарлах. Жишээлбэл: Хэлцэд сайшаасан юмуу, муушаасан утгын аль нь давамгайлж байгаагийн учрыг тайлбарлан ярилцах. Оньсогод юуг юутай адилтгаж, юугаар төлөөлүүлж оньсоголсныг товч тайлбарлах. “Уран дүрслэл” - ийн нэмэлт тайлбаруудыг ашиглана. ▪ Эх сурвалж нь аль хэр баттай вэ? Эдгээрийг сайтар анхаарвал ярианы сэтгэлд хоногших, урам сэргээх, ухаан бодлыг тэлэх, сайн сайхан итгүүлэх, муу муухайг жигшүүлэх нөлөөлөл нь илүү болно. ▪ Сонгосон жишээ баримт, эшлэл, уран дүрслэл, хэлцийг дараах шалгуураар нягталж шалгана. ▪ Сэдэвтэйгээ тохирч байна уу? ▪ Аль зэрэг түгээмэл шинжтэй вэ? ▪ Хангалтгүй жишээ баримт, эшлэл, уран дүрслэл, хэлц болсон уу? ▪ Сонсогчийн сэтгэлийг хөдөлгөж чадсан уу? <p>Жишээ нь: Ертөнц дээр юмс үзэгдэл нэг нь нөгөөтэй давтагдашгүй өөр өөрийн өнгө төрхтэй байдаг тухай өгүүлэхдээ Инжинашийн “Хөх судар” романы “Товчит толт” - ын 2 дугаар ангид байдаг “Үлгэрлэвээс ертөнцийн уур амьсгал туйлын сайхан өнгөт нь цэцэг атал цэцэг бүр адил үгүй, өөр өөртөөн нэгэн зүйлийн сайхан өнгө буй. Бас ертөнцийн уур амьсгалын амттайхан нь жимс бөгөөтөл жимс бүр адил үгүй, тус тусдаан нэгэн зүйлийн амттайхан амт буй.” гэснийг эш татахад энэ нь уран дүрслэлийн жишээг оновчтой эш татсан хэрэг болно. Энэ мэтээр сурагчдын яриандаа сонгож авсан жишээ баримт, эшлэл, уран дүрслэл, хэлц дээр нухацтай үнэлэлт дүгнэлт өгч ажиллана гэсэн үг.</p>	
--	--	--

ҮГИЙН САН, ХЭЛ ЗҮЙ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.4а. Өгүүлбэрийн гишүүдийн хэлбэржилт утга байрыг тодорхойлох, эхийн найруулгад гүйцэтгэх үүргийг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> - Өгүүлбэрийн цөм бүтцийг ялгах - Гишүүн бүрийн утга, байр, хэлбэржилтийг тайлбарлах - Өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлох, тайлбарлах - Өгүүлбэрийн гишүүдийг гол ба дэлгэрүүлэгч гишүүн гэж ангилдийг сэргээн санах - Гол гишүүд (өгүүлэгдэхүүн, шууд тусагдахуун, өгүүлэхүүн)-ийн утга, үүргийг тодорхойлох - Дэд гишүүд (тодотгол, шууд бус тусагдахуун, байц) гэж ангилдийг сэргээн санах - Загварт тохируулан өгүүлбэр зохиох 	

	<p>Дэд гишүүдийг хасах, нэмэх замаар өгүүлбэрийг хурааж, дэлгэрүүлэн өгүүлбэрийн гишүүдийн үүргийг тодорхойлох</p>	
<p>10.4б. Зэрэгцүүлэн, угсруулан холбох бүтээвэр, үгийн утгыг ялган таних тайлбарлах</p>	<ul style="list-style-type: none"> - Эх өгүүлбэрийн хэл зүйн холбоосуудад ажиглалт хийх, харьцуулсан утга бүхий өгүүлбэрүүдийн холбоос найруулгын учир холбогдлыг илрүүлэх. - Нийлмэл өгүүлбэр ба цогцолборуудыг холбох холбоос нь эхийн доторх агуулгад ямар өөрчлөлт оруулж байгааг судалж унших - Харьцуулан тайлбарлаж бичсэн эхийг уншиж, цогцолбор ба өгүүлбэрт юмс үзэгдлийг бүхэлд харьцуулсан уу, хэсэглэн харьцуулсан уу гэдгийг тодруулан тайлбарлах - Харьцуулан жишиж бичихийн тулд сонгосон өвөрмөц үг хэллэгт анхаарлаа хандуулж дүгнэлт гаргах. Тухайлбал: 1940 оны сургуулийн амьдралыг өнөөгийн сургуулийн амьдралтай харьцуулан бичихийн тулд “Сурагч Ганбат” туужид “Ленин, Чойбалсангийн үгийг сургуулийн танхимд алтан үсгээр сийлж” хэмээн бичсэний учрыг тайлбарлахын тулд сурагчид бичил судалгаа хийх <p>Багшид зөвлөх нь: Уншигчийн анхаарлыг татахын тулд ашигласан дүрслэх үг хэллэгийг тодруулахын тулд: Асуултын дагуу задлан шинжилгээ хийж болно. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Аль насныханд зориулсан ▪ Ямар ямар үг хэллэгийн ялгаа байгаа ▪ Дүрслэлийг аль хэсэгт илүү ашигласан? ▪ Аль хувилбар нь ямар учраас илүү үнэн бодитой санагдаж байна вэ? ▪ Сурагчдад аль нь илүү ойлгомжтой байна вэ? ▪ Түүхийг өгүүлэхдээ хэвшсэн зарчмаас гажсан зүйл байна уу? гэх мэтээр анализ хийсний дараа тухайлсан жишээ өгүүлбэрүүдийг харьцуулан бичихэд бэлтгэнэ. <ul style="list-style-type: none"> - Харьцуулахдаа хэрэглэсэн аргыг тодруулахын тулд: - Харьцуулсан өгүүлбэрүүдэд түгээмэл тохиолддог холбоосуудыг илрүүлэн, утгын ангилал хийнэ. (Бол, харин, ж бол, гэхдээ, атлаа г.м.) 	<ul style="list-style-type: none"> - Тайлбарласан эсээ - Л.Түдэв “Өс өвөрлөх”, “Ус гүйдэл”, “Дулаарлын айдас”, “Хурд нэмэх жам”, “Номын садан”, “Үхэр хулгана-харх” эсээ - Төрөл бүрийн хөрөг найруулал
<p>10.4в. Ойролцоо, эсрэг утгатай бүтээвэр, үг өгүүлбэрийн утгыг ойлгох хэрэглэх</p>	<ul style="list-style-type: none"> - Ойролцоо, эсрэг утгатай нэгжүүдийг таних, ялгах - Хэлний нэгжүүдийн утга ойролцоо, эсрэг болохыг тайлбарлах - Ойролцоо, эсрэг утгат нэгжүүдийг эхэд сонгосон шалтгааныг тайлбарлах - Ойролцоо, эсрэг утгат нэгжүүдээс сонгон хэрэглэх - Үгийн утгыг хам сэдвийн хүрээнд тайлбарлах, тодорхойлох 	<p>Харьцуулан тайлбарласан эхүүд</p>
<p>10.4г. Бичгийн найруулгын зэргийг ялгах</p>	<ul style="list-style-type: none"> - Бичгийн найруулгын зэргийг ялгах - Найруулгын зэрэг бүхий үг хэллэгийг ялгах - Бичгийн найруулгын зэргийг тодорхойлох - Бичгийн найруулгын зэргийг хам сэдвийн хүрээнд тодорхойлох - Найруулгад сонгосон үг, өгүүлбэр, дүрслэлд үндэслэн найруулгын зэргийг тодорхойлох - Найруулгын ялгамжааг ойлгох, үг хэллэгийг оновчтой хэрэглэх 	<p>-Албан бичгийн сонгодог</p>

	<p>- Сонгодог бичгийн хэлний хүндэтгэлийн үг хэллэгийг тайлбарлах</p> <p>Багшид зөвлөх нь: Найруулгын зэргийг “дээд”, “дунд”, “дунд” гэж ангилдаг ерөнхий ойлголтыг өгнө. Дээд буюу эрхэмсэг хүндэтгэлийн, ерийн буюу найруулга дундын, доод буюу хар ярианы гэсэн гурван зэргээр ангилж үздэг. Найруулгын дээд өнгө аястай үг хэллэгт бичиг зохиолын хэлний дээд хэм хэмжээнд тохирох үг багтдаг. Доод өнгө аястай үг хэллэгт этгээд, завхай, бүдүүлэг үг зэрэг бичиг зохиолын хэлний боловсронгуй найруулгад үл тохирох үг ордог. Найруулгын дээд өнгө аястай үг хэллэгт хуучирсан үг, шинэ үг, яруу найргийн үг, гадаад үгийг оруулан үздэг боловч эдгээр нь доод өнгө аястай найруулгын дотор ч байж болдог. Гэхдээ гол ерөнхий шинжээрээ ном судрын боловсронгуй найруулгад байх учраас дээд өнгө аястай үгэнд багтаан үздэг. Тухайн найруулгад орж байгаа үг нь үгийн сангийн аль давхрагад багтаж байгаатай үгийн өнгө ялгараа нь холбоотой байдаг. Найруулга дундын үг найруулгын үүргээрээ өнгө аяс нь аяндаа тодордог.</p>	<p>найруулгын эхүүд</p> <p>- Нийтлэл эхүүд</p>
--	---	---

10 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ СОНГОН СУДЛАХ СУРГАЛТЫН ЦӨМ ХӨТӨЛБӨРИЙН ЗӨВЛӨМЖ

Энэхүү баримт бичиг нь монгол хэл бичгийн сонгон судлах шинэчилсэн хөтөлбөрийн дагуу аравдугаар ангид хичээл сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зааж хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт хийхэд, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой удирдамж болно.

Суралцахуйн удирдамжийг боловсруулахдаа цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэл болох, багш нарын хичээлээ төлөвлөх, арга зүйн болон хэрэглэгдэхүүнийг сонгоход баримжаа болгохыг зорьсон. Иймд тодорхой агуулгын сургалтын цагийг тухайн ангийн сурагчдын онцлог, суралцах хурдтай уялдуулан зохицуулах боломжтой. Суралцахуйн удирдамжид санал болгосон үйл ажиллагаа, хэрэглэгдэхүүнийг сонгон хэрэглэхээс гадна хөтөлбөрийн агуулга дахь суралцахуйн зорилтод нийцэх бусад эх сурвалжаас ашиглаж болно.

УНШИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.1а. Албан бичгийн найруулга дахь эхийн бүтэц, хэлний нэгжийн байр, утга, үүргийг тодорхойлох, онцлогийг тайлбарлах</p>	<ul style="list-style-type: none"> - Албан бичгийн сонгосон төрлүүд болох албан захидал, илтгэл, тодорхойлолт, ажлын удирдамж зэргийг унших - Цогцолбороор задлах - Цогцолбор бүрд ямар агуулга тусгасан байгааг ажиглах, хэлэлцэх - Бичих бүтэц дарааллыг тулгуур үгээр жагсаан гаргах Жишээ нь: Тодорхойлолтыг уншаад бүтэц дараалал, тэдгээрийн уялдаа холбоог тодорхойлохдоо, дараах бүтэцтэй байдгийг ойлгох. Үүнд: - Намтрын хэсэг (Хэний хэн, хэдэн онд хаана төрсөн. Төгссөн сургууль курс, эзэмшсэн мэргэжил.) - Ажлын байдал (Хэдээс хэдэн онд хаана хаана ямар ажил хийж байсан.) - Гавьяа шагнал (Хэзээ юуны учир ямар гавьяа шагнал цол, зэрэг хүртсэн.) - Үнэлэлт (Ажил төрөл, ааш зангаар ямар хүн болох) - Албан бичгийн найруулгын үгийн сангийн онцлогийг тодорхойлох 	<p>Төрөл бүрийн ажлын удирдамж, албан захидал, илтгэл, тодорхойлолт (ажил байдлын, сурлага хүмүүжлийн,</p>

	<ul style="list-style-type: none"> - Албан бичиг нь уншиж буй хүнд тодорхой ойлгомжтой байх ёстой гэсэн зарчимтэй байдгийг мэдэх - Үг хэллэгийг шууд буюу гол утгаар нь сонгон найруулж байгаагийн учрыг тайлбарлах - Уран дүрслэл, зүйр цэцэн үг болон хар ярианы үг хэллэг, нутгийн аялгууны үгс, этгээд бүдүүлэг үг, хэлц зэрэг утга зохиолын хэлний идэвхгүй үгс буюу бичиг зохиолын найруулгад нарийн зааг хязгаартай, тодорхой үүрэгтэй ордог үгс огт ордоггүй байгаагийн учрыг тайлбарлах - Албан бичгийн найруулгад олон удаа орсоор нэгэнт хэвшин тогтсон, бусад найруулгад бараг ордоггүй албархаг үг хэллэгүүдийг түүвэрлэж, найруулгад ямар үүрэг гүйцэтгэж байгаа талаар ярилцах - Албан бичгийн найруулгын үг хэллэгийн давтамж (давтагдан орох байдал) маш их байдаг бөгөөд түүнийг өөр үг хэллэгээр солин найруулахгүй байгааг судалж, тайлбарлах - Ажлын удирдамж, албан захидал, илтгэл, тодорхойлолт зэрэг албан бичгийн төрлүүдийг сонгон унших замаар албан бичгийн найруулгын өгүүлбэр, үг, бүтээврийн найруулгын онцлогийг тодорхойлох - Албан бичиг дэх өгүүлбэрийн найруулгын онцлогийг судлах - Албан бичгийн эхийн өгүүлбэрийн утгыг анхаарч унших - Өгүүлбэрийн бүтцийг ажиглах - Тоочсон, зэрэгцсэн өгүүлбэрүүд ашиглаж байгаагийн учрыг ярилцах - Албан бичгийн төрөл, зүйлийн онцлогоос шалтгаалан өгүүлбэрийн утга болон бүтцийн хувьд нийтлэг болон ялгаатай шинжийг харьцуулан гаргах - Нийлмэл өгүүлбэрүүдийг холбосон хэрэглүүрүүдийг ажиглан зэрэгцүүлэх болон учир шалтгааны утгатай холбох хэрэглүүр түлхүү хэрэглэж байгаагийн учрыг ойлгож тайлбарлах - Албан бичиг дэх үг хэллэгийн найруулгын онцлогийг судлах - Албан бичигт хэрэглэсэн үгсийн утга, найруулгын үүргийг - Хэнд хандсан ямар төрлийн баримт бичиг болохоос шалтгаалан хүндэтгэлийн болон энгийн үг хэллэг хэрэглэж байгаагийн учрыг ойлгож, найруулгын үүргийг тодорхойлох - Нэг үгийг олон удаа давтсан байгааг ажиглаж өөр ойролцоо утгатай үгээр нь солин найруулбал албан бичгийн найруулгын өнгө аясад ямар өөрчлөлт гарч байгааг судлан тогтоох - Ихэнх албан бичигт уран дүрслэл, чимэг үг зэргийг хэрэглэхгүй, зарим албан бичигт ганц нэгээр хэрэглэсэний учрыг тайлбарлах - Албан бичиг дэх бүтээврийн найруулгын онцлогийг судлах - Хэл найруулгын онцлогийг нь харьцуулах 	<p>лавлагаа, магадлагаа)</p>
--	---	------------------------------

	<ul style="list-style-type: none"> - Албан бичгийн төрлүүдийг хооронд нь өгүүлбэр, үг, бүтээврийн хэрэглээ, хэл найруулгын талаас нь харьцуулах - Уран зохиолын найруулгын эхтэй албан бичгийн найруулгын эхийг харьцуулан зохиогчийн зорилгын үүднээс тайлбарлах 	
<p>10.16. Албан бичиг дэх батлах, нотлох, үгүйсгэх, хориглох, захирах, тушаах, зөвшөөрөх, хүсэх, уриалах, үнэлж дүгнэх зэрэг баймж утгын үүрэг хэрэглээг ажиглаж ойлгох</p>	<ul style="list-style-type: none"> - Албан бичигт баталж, нотлох утга ямар үг хэллэг, бүтээврээр илэрч байгааг тогтоож, ярилцах - Үгүйсгэх, хориглох баймж утга илэрхийлж байгаа түгээмэл хэрэглэгдэх сул үг болон бүтээврийг ялгах - Захирах, зөвшөөрөх, хүсэх баймж утга илрүүлж байгаа хэлний нэгжийг тогтоож, тайлбарлах - Албан бичгийн төрөл, хэлбэр, хэнд хандаж байгаагаас шалтгаалан ялгаатай хэрэглэх баймж утгуудыг илрүүлж учрыг тайлбарлах Жишээ нь: захирах, зөвшөөрөх, хүсэх гэх мэт - Батлах, нотлох баймж утга бүх албан бичигт нийтлэг илэрч байгааг ажиглан тайлбарлах - Албан бичгийн өгүүлбэр, хэллэгт эргэлзсэн, таамагласан, шоглож хошигносон, санал бодол хуваалцсан зэрэг өгүүлэгчийн сэтгэлийн аяс илэрхийлсэн утга илрэхгүй байгаагийн учрыг тайлбарлан ярилцах - Бичиж буй албан бичгийн бүтэц, шаардлагад нийцүүлэн баймж утгыг оновчтой сонгон хэрэглэх 	<p>Төрөл бүрийн ажлын удирдамж, албан захидал, илтгэл, тодорхойлолт (ажил байдлын, сурлага хүмүүжлийн, лавлагаа, магадлагаа)</p>

БИЧИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.2а. Ажлын удирдамж, албан захидал, илтгэл, тодорхойлолтыг тогтсон заавар, загварын дагуу бичих</p>	<ul style="list-style-type: none"> - Албан бичгийн найруулгын шаардлагыг ойлгох - Тогтсон бүтцийг барьж бичих - Товч, тодорхой, ойлгомжтой бичих - Тоочих өгүүлбэр бичих - Өгсөн загвараар төрөл бүрийн эх бичих - Эхийн төрөл зүйлүүдийн онцлогт тохирсон бүтцээр бичих - Өөр хоорондоо бүтэц, бичлэг, хэмжээгээрээ ялгаатай найруулгад баримтлах нийтлэг шинжээрээ адил гэсэн зарчмыг эх бичих явцдаа ойлгох - Албан бичгийн найруулгаар бичих төлөвлөгөө зохиох - Төлөвлөгөөний дагуу мэдээлэл олох, ангилан ялгах - Мэдээллийг цэгцэлж нэмэх хасах зүйлийг тунгаан бодох, засварлах - Цогцолборыг төрөл бүрийн холбоосоор холбон найруулж бичих - Найруулгын алдаагаа хянах, засаж сайжруулах - Албан бичгийн найруулгын шаардлагын дагуу төрөл бүрийн эхийг компьютерээр бичих 	<p>Төрөл бүрийн ажлын удирдамж, албан захидал, илтгэл, тодорхойлолт (ажил байдлын, сурлага хүмүүжлийн, лавлагаа, магадлагаа)</p>

	<ul style="list-style-type: none"> - “Word, excel” программ ашиглаж албан бичиг төлөвлөх, бичиж найруулах - Бичиг баримтын бүрдэл бүрдүүлэх ойлголттой болох - Бүтээлийн сан хийх 	
<p>10.26. Эхийн найруулгын төрөл, хэв маягийн онцлогт тохирсон бүтэц, хэлний нэгжийг сонгон найруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Бичих зорилго, уншигчийн онцлогт тохирсон сэдэв сонгох, сэдвийн хүрээнд мэдээлэл цуглуулах, мэдээллийг ангилж бүлэглэх, бичих зүйлээ төлөвлөх, бичих хэлбэрийг сонгож бичих, бичсэнээ хянах, сайжруулан бичихдээ санаагаа бүрэн гүйцэд, тодорхой, уялдаа холбоотой илэрхийлэн бичих - Хэнд зориулж, ямар зорилгоор бичихээс шалтгаалан эх бичвэрт сонгож хэрэглэх үг хэллэг, бүтээвэр өөр өөр байхыг ойлгох - Албан бичгийн хуулийн үг хэллэг, өдөр тутмын сонины үг хэллэгээс ялгаатай байдгийг мэдэх - Товч мэдээ, зар, зурхай, үгийн сүлжээ гэх мэт төрөл бүрийн сонины хайчилбар ба албан бичгийн хууль, ажлын удирдамж гэх мэт эхүүдээс хайчилбар хийн харьцуулах - Харьцуулан ажиглах, өгүүлбэр, үг хэллэг, бүтээврийн нарийн ялгааг тодруулах - Үг ба бүтээврийг эхийн найруулгын онцлогт тохируулан, хам бичвэртэй зохицуулан сонгох - Салаа утгат үг хэллэгийг аль утгаар нь аль найруулгад хэрэглэхийг мэдэх - Ёслол хүндэтгэлийн эрхэмсэг өнгө аястай, эсвэл яруу найргийн сэтгэл хөдлөлийн ялгараатай үгийг хэзээ хаана, ямар найруулгад хэрэглэхийг ойлгох - Ийм үг хэллэг илэрхийлж байгаа агуулгадаа нийцэж байгаа нийцэхгүй байгааг ялгаж сурах. Жишээ нь: Хэтэрхий сүрлэг, ёсорхуу сонгодог бичгийн хэлний өнгө аястай үг хэллэгийг эхийн агуулга, сонгож буй ухагдахуундаа нийцүүлэлгүй хоосон дуурайлгавал найруулгын алдаа болохыг ойлгох - Найруулгын өнгө аясад үл тохируулан хам бичвэрийн дотор найруулгын өнгө ялгараа нь эрс тэс ондоо үг хэллэгийг хамтатган хэрэглэвэл эхэд хошин шог өнгө аясыг илрэхийг ойлгох - Ийм төрлийн олон хувилбарт өгүүлбэрийн жишээн дээр ажиллах. - Албан хэрэгт үгийг оновчтой сонгон хэрэглэх чадварыг хөгжүүлэхийн тулд эхийг эвлүүлж найруулах, алдааг сийрүүлэх, хураах, дэлгэрүүлэх - Уран зохиолын эхийг албан бичгийн эхийн найруулгад хувиргаж бичих 	<p>Төрөл бүрийн ажлын удирдамж, албан захидал, илтгэл, тодорхойлолт (ажил байдлын, сурлага хүмүүжлийн, лавлагаа, магадлагаа)</p>

<p>10.2в. Эх, өгүүлбэрт баймж утгыг оновчтой илэрхийлэх, цэг тэмдгээр ялгах</p>	<ul style="list-style-type: none"> - Эх өгүүлбэрт өгүүлэгч этгээд өгүүлж буй зүйлээ сайшаасан, эс сайшаасан, зөвшөөрсөн-эс зөвшөөрсөн, буруушаасан, зэмлэсэн, гайхсан, эргэлзсэн, таамагласан, үл итгэсэн, анхааруулсан гэх мэт янз бүрийн хандлагыг илэрхийлсэн хэлний нэгжийг олж тэмдэглэж, унших - Бүтээвэр, үг, өгүүлбэрийн найруулгад илрэх өнгө аяс, үнэлэмжийн ялгарааг тайлбарлах - Зохиолчийн хандлагыг жишээгээр батлан тайлбарлах - Итгэсэн, эргэлзсэн, дурлаж шимтсэн, хүсэж гуйсан, захирч тушаасан, сануулсан, ерөөсөн ... гэх мэт хандлагыг илэрхийлсэн эх, өгүүлбэр зохиох - Хандлагуудыг өөрчлөн илэрхийлэх - Тохирох баймж утга бүхий хэлний нэгжийг нөхөх - Бүтэц бус өгүүлбэрээр илрэх баймж утгыг тайлбарлах - Бүтэц ба бүтэц бус өгүүлбэрийг хослон зохиох - Баймжит бүтээвэр болон бүтэц бус өгүүлбэртэй холбогдсон зөв бичих дүрмийг судлах - Эх өгүүлбэрт цэг тэмдэг нөхөх зэргээр ажиллах - Цэг тэмдгийн алдаа засах <p>Багшид зөвлөх нь: Баймж утга гэдэг нь өгүүлэгчээс тухайн зүйлд хандах хандлагыг хэлдэг. Тиймээс баймж утгат хэлний нэгжүүдийг хэрэглэж сурахын тулд эхлээд өгүүлбэр зохиох, өгүүлбэрийг нөхөх, солин найруулах зэрэг энгийн даалгавруудыг гүйцэтгэнэ. Үүний дараа эх зохион бичихдээ хэрэглэж сурахад анхаарна. Эх зохион бичих сэдэв сонгосныхоо дараа уг асуудалд бичигч өөрөө ямар хандлагаар бичихээ төлөвлөнө. Тэгээд сэдэв, санаа, өөрийн хандлагадаа тохируулан хэлний нэгжүүдээ сонгоно. Баймж утгат хэлний нэгжүүдийг хэрэглэснээрээ бичигчийн уг зүйлд хэрхэн хандаж хадлага нь уншигчдад тодорхой болдог. Өөрөөр хэлбэл бичигч өөрийнхөө “би”-г бусдад таниулах нэг арга гэж ойлгож болно. Баймжтай холбоотой дасгалыг Б.Пүрэв-Очир, А.Цог-Очир нарын “Монгол хэл 10” номын 61-66-р хуудсанд байгаа даалгавруудаас сонгон ажиллаарай. Ялангуяа эсээ болон шүүмж бичихэд баймж утгат нэгжийг хэрэглэх хэрэгтэй. Баймж утгат хэлний нэгжийг цэг тэмдгээр ялган бичихдээ дараах дүрмийг анхаарна. 1. Асуух үг бэ, вэ заримдаа урт эгшигтэй, заримдаа эгшиггүй хэлэгдэх боловч богино эгшигтэй бичнэ. В,Л,М, Н үсгээр төгссөн үгэнд бэ-г бичнэ. Харин үүнээс бусад эгшиг, гийгүүлэгчээр төгссөн үгэнд вэ-г бичнэ. Асуух өгүүлбэрийн эцэст асуултын тэмдэг тавина. 2. Асуух үг юу, юу хоёрыг урт ба хос эгшгээр төгссөн үгэнд</p>	<p>Төрөл бүрийн ажлын удирдамж, албан захидал, илтгэл, тодорхойлолт (ажил байдлын, сурлага хүмүүжлийн, лавлагаа, магадлагаа)</p> <p>Төрөл бүрийн ажлын удирдамж, албан захидал, илтгэл, тодорхойлолт (ажил байдлын, сурлага хүмүүжлийн, лавлагаа, магадлагаа)</p>
--	--	---

	<p>эгшиг зохицох дүрмээр бичнэ. Үүнээс бусад богино эгшиг, гийгүүлэгчээр төгссөн үгэнд уу, үү-г бичнэ. Асуух өгүүлбэрийн эцэст асуултын тэмдэг тавина. 3. л, ч, шүү гэх зэрэг баймжит бүтээврийг өмнөх үгээс нь саланги бичнэ. 4. Даа, дээ, доо, дөө гэсэн баймжит бүтээврүүдийг эгшиг зохицох дүрэм баримтлан өмнөх үгээс нь саланги бичнэ. 5. Хандаж хэлсэн “аа, ээ, оо, өө” дөрвийг эгшиг зохицох дүрмийг баримтлан, өмнөх үгээс нь саланги бичнэ. Хандаж хэлсэн үгийн дараа анхаарлын тэмдэг бичнэ. 6. “А” язгуур нь гээгдсэн “сан”, “даг” нөхцөлийг уг үгээс нь саланги эгшиг зохицох дүрмийн дагуу бичнэ. Бүтэц бус өгүүлбэрийн ард анхаарлын тэмдэг тавина.</p>	
--	--	--

СОНСОХ-ЯРИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.3а. Дэвшүүлсэн асуудлыг дэд сэдвээр дэлгэрүүлж ярьж илтгэхдээ шинэ санаа дэвшүүлэн, баримт жишээ, тоон үзүүлэлт, дуут ба дүрс бичлэг, зураг зэргээр санаагаа батлах, үгүйсгэх, ерөнхийлөн дүгнэх</p>	<ul style="list-style-type: none"> - Өгүүлэх гэж буй зүйлийн ерөнхий сэдвийг тодорхойлох - Тодорхой сэдэв буюу дэд сэдвүүдийг тодорхойлох Жишээ нь: “Монгол хэл бол хүн төрөлхтний оюуны соёлын нэг хэсгийг тээж ирсэн эртний том хэл.” “оюуны соёлын нэг хэсэг, тээж ирсэн, эртний хэл, том хэл” гэсэн ерөнхий сэдвийн дор асуудлын дор өгүүлэгч өөрийн өвөрмөц шинэ санаа бүхий дэд сэдвийг хөндөж болно. Жишээ нь: “Эх хэл эвдрэхийн дэргэд эдийн засаг хямрах зэрэг бол юу ч биш.” гэсэн асуудал дэвшүүлбэл дээрх ерөнхий сэдэв нь өгүүлэгчийн өвөрмөц шинэ санаагаар баяжин, илүү тодорхой болох нөхцөл бүрдэж байна гэсэн үг. - Өвөрмөц шинэ санаанд гол анхаарлаа хандуулж, хэлэлцэх, дүгнэх - Үндсэн зорилго нь сонсогчдын сэтгэлийг сэргээх, шинэ зүйлийг мэдээлэх, итгүүлэн сэнхрүүлэх, уриалан дуудах явдал бөгөөд агуулга нь утга төгөлдөр байх ёстой гэдгийг ойлгох - Ярианы үндсэн зорилго бол сонсогчдын хүлээн авах, асууж сонирхох, өөрөө хариулах тэмүүллийг бий болгоход чиглэдэг гэдгийг өгүүлэгч анхаарч бусдаас өөр, ялгарахуйц санааг эрж хайх - Ярих зүйлээ төлөвлөх, арга хэлбэрийг сонгох - Яриагаа төлөвлөх, баримтыг хэрхэн харьцуулж, ямар дүгнэлтэд хүрэхээ төлөвлөх - Яриагаа ноороглон бичих - Ярьж илтгэх - Бусдын ярианд үнэлгээ өгөх, харьцуулах, санал, сэтгэгдлээ хэлэх - Цуглуулсан мэдээллийг эрэмбэлэх, ялгах, хэрэгтэйгээ сонгох <p>Багшид зөвлөх нь:</p>	<ul style="list-style-type: none"> - Төрөл бүрийн уран илтгэлүүд - Асуудал дэвшүүлсэн эсээ, нийтлэл - Сонин сэтгүүл - Ном зохиол - Толь бичиг - Цахим хэрэгсэл - Кино - Видео бичлэг гэх мэт

Үг хэлэхэд хамгийн чухал нь анхаарал татахуйц сонирхолтой **эхлэл** байж болно. - Ямар нэгэн асуулт тавих - Бодит явдлын хүүрнэсэн яриа - Аль нэг гайхалтай эш татсан үгээр эхлэх - Хачирхалтай баримт үзүүлж эхлэх гэх мэт. Тухайлбал: Бальтиморын Баллантины мастер Н “Радиогийн гайхамшиг” сэдвээр хэлсэн үгээ “Нью-Йоркийн цонхны шилэн дээр явж байгаа ялааны гаргаж буй чимээг Ниагарын хүрхрээний дууны дайтай нэмэгдүүлээд, Төв Африкт радиогоор дамжуулж болно гэдгийг та сэтгэлдээ ургуулан бодож чадах уу?” гэж эхэлсэн байдаг. Дэвшүүлсэн асуудлыг дэд сэдвээр дэлгэрүүлж ярьж илтгэхдээ баримт жишээ, тоон үзүүлэлт, дуут ба дүрс бичлэг, зураг зэргээр санаагаа батлах, үгүйсгэх, ерөнхийлөн дүгнэх гэдэг нь эхэд ашиглах хэрэглэгдэхүүний хүрээний асуудал юм. Үүний тулд: Ярих сэдвийг сонирхол, хэрэгцээндээ тулгуурлан сонгох. Жишээ нь: - “Хурд - Хөгжил” Тухайн сэдвээр ямар санаа дэвшүүлэхээ бодох, гол санаа буюу түлхүүр өгүүлбэрээ олох - Ярих сэдэвт холбогдох мэдээлэл, хэрэглэгдэхүүн цуглуулах, ангилж бүлэглэх - Гол санаагаа дэмжих баримтаа цуглуулах, юуг юутай ямар баримтыг харьцуулж, санаагаа батлахыг бодож, баримтаа цэгцлэх - Сонсогчдын сониуч занг хөдөлгөх, амьдралд тохиолдсон бодит явдлаас эшилсэн, итгэл үнэмшил төрүүлэх жишээ баримтыг тохируулан сонгох

Сурагчид анги танхимд чөлөөтэй санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж сурахын тулд бие биеэ шоолох, шүүмжлэх, эсвэл буруу зүйл хэлэхээс айдаг орчныг бүрдүүлэхээс багш нар болгоомжлох хэрэгтэй юм. Тиймээс сургалтын явцад хүүхдүүд чөлөөтэй оролцож сурахыг багш хичээлийн явцад сургана. Тухайлбал: “Халуун сандал” аргыг ашиглаж болно. Энэ арга нь эхэн үедээ сурагчид биеэ барих, бусдын өмнө гарахаас ичих, сандрах гэх бэрхшээлтэй тулгарах боловч хэд хэдэн удаа гарсны дараа биеэ барих, айх ичих нь багасаж хүүхэд сургалтын үйл явцад чөлөөтэй оролцож эхэлдэг. Гагцхүү үүнд сургахын тулд багш суралцагчийг зөв удирдан чиглүүлэх шаардлагатай юм. **Халуун сандал:** Нэг сурагч анги танхимын урд гарч сууна. Энэ суудлыг халуун суудал гэх ба халуун суудалд суусан хүүхэд даалгаврыг гүйцэтгэнэ. Тухайлбал: 1. Өгүүлбэрийг хэлцээр дэлгэрүүлж хэлэх 2. Өгүүлбэрийг уран дүрслэлээр дэлгэрүүлж хэлэх 3. Өгүүлбэрийг тоо баримтаар дэлгэрүүлж хэлэх 4. Өгүүлбэрийг эшлэлээр дэлгэрүүлж хэлэх 5. Бусдын санааг дэмжих, эсвэл үгүйсгэж батлах . “Халуун сандал” - д суусан сурагч 5 асуултад хариулснаар солигдох. Унагаах асуулт асуусан сурагч “халуун сандал” – д суух гэх мэтээр үргэлжлүүлнэ. Халуун сандалд суусан суралцагчаас холбогдолгүй асуулт асууж, цаг авах магадлалтай тул ямар асуулт, даалгавар асууж болохыг багш чиглүүлж, сурагчдын дэвтэрт урьдчилан бэлдүүлнэ. Тухайлбал:

	<ul style="list-style-type: none"> - Өгүүлбэр ба хэлцийн хүрээнд - Өгүүлбэр ба тоо баримтын хүрээнд - Өгүүлбэр ба уран дүрслэлийн хүрээнд гэх мэтээр хязгаарлаж өгвөл сайн. Мөн багш “Халуун сандал”-д сууж болно. Энэ үед сурагчид багшийг төөрөгдүүлэх асуултыг эрж хайна. Хөрштэйгөө, эсвэл багаар хамтран зохионо. Үүний дараа багш сурагчдаас ямар асуулт асуухад түвэгтэй хэцүү байсан тухай ярилцаж, эрсдэл хийх, чадвар сорьсон даалгаврыг гүйцэтгэх оролдлого хийх урам зоригийг бадрааж өгвөл сайн. Ийм орчинг бүрдүүлж чадвал багш, сурагчдын хооронд чөлөөтэй харилцаа бий болж, суралцагч юуг, хэрхэн сайжруулахаа олж мэдэх бололцоотой болж, багшийн суралцах үйл явцыг хэрхэн дэмжих аргаа олоход нэмэр болно. Багш сурагчдын тавьсан асуултаас тэдний ойлголтын зөрүүтэй байдал, чадварын түвшинг тодруулж анализ хийх боломжтой. Энэ үед дүн онооны өрсөлдөөнт байдлаас илүү сурагчид анги танхимын орчинд, сургалтын үйл явцад чөлөөтэй оролцож, асуултыг зөв оновчтой тавьж сурах сэдэл үүсгэх нь чухал. Халуун сандалд суусан сурагч нь зөвхөн асуултад хариулах бус, сурагчдын тавьсан асуултаас, алдаатай асуултыг олж чадвал бүр сайн юм. Багш нар суралцагчийг бусад суралцагчтай харьцуулахаас зайлсхийх хэрэгтэй, гэхдээ суралцагчийн тавьсан асуулт, хариултаас хамгийн сонирхолтой чанартайг нь сайшаан магтаж, маш сайн гүйцэтгэсэн үлгэр жишээ ажил болгон ашиглаж болно. 	
--	---	--

ҮГИЙН САН, ХЭЛ ЗҮЙ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.4а. Үгийн санжсан, утгазүйжсэн, хэл зүйжсэн холбоо үгийн утга, бүтцийг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> - Өгүүлбэр цогцолбороос хэлц холбоо үгийг ялган, утга бүтцээр нь тайлбарлах - Үгийн санжсан холбоо үгсийг ялган таньж, утга бүтцийн тайлбар хийх - Өгүүлбэрт ажиглалт хийгээд хэлц холбоо үгсийг тэмдэглэх - Учрыг тайлбарлах - Төрөл бүрийн аргаар дэлгэрүүлэн найруулах - Ангилан ялгах - Өгүүлбэр зохиох - Карт бэлтгэж ялгах - Толь бичиг хөтлөх - Утгын ялгаатай талыг тодорхойлох <p>Багшид зөвлөх нь: Дараах онолын тайлбарыг бүтээлчээр ашиглана. Үгийн санжсан холбоо үг: - Салаа утгагүй, дүрслэх ур маягаар бүтээгүй үгс Жишээ нь: сэтгэл санаа, мөхөх бөхөх, жин тан,</p>	

	<p>цайлган цагаанмандах буурах, өндөр нам, хар цагаан, дээр доор гэх мэтээр эсрэг ойролцоо гэх мэт янз бүрийн утгатай хоршоо үгс Содбаяр, Баянгол, Улаанбаатар, белаз машин, хунтайж гэх мэт нийлмэл үгс болон хоёроос дээш үг нийлж бүтсэн шууд утгатай - Албан бичгийн болон нийтлэл, уран зохиолын төрөл бүрийн эх ба оноосон нэрүүд орно.</p> <p>- Нэр томъёоны шинжтэй, нэг ухагдахуун тэмдэглэнэ. Жишээ нь: “төмөр зам” – гэхэд “төмөр”, “зам” гэсэн 2 үг нийлж “галт тэрэг явах нэг зүйл зам” гэсэн нэг ухагдахууныг илтгэж байна. Хэлзүйжсэн холбоо үгсийг эх өгүүлбэрээс дараах онцлогоор нь ялган таньж, утга бүтцийг нь тайлбарлана. - “бай-, бол-” гэх мэт туслах үйл үг нь үйл үгийн дараа орохоос гадна нэрийн дараа орж үйлшүүлнэ. Жишээ нь: ажил хийх- ажиллах, мөрөөдөл болох- мөрөөдөх, явж байх, хийдэг болох, уншсан байх гэх мэт - Зарим бие даасан үйл үг нь үйлийн болцын утга заана. Жишээ нь: “үгэлж гарлаа”, “хэрэлдээд уналаа” гэхэд үйлийн эхлэх, “уншиж сууна” гэхэд үргэлжлэх, “цадах шахлаа, өнхрөөд өглөө” гэхэд дуусах явцыг заасан утгатай болж хэлзүйжсэн байна. - Баймж утга илтгэнэ. Жишээ нь: “уншиж чадна”, “судлах хэрэгтэй” гэх мэт. “Бат ирж мэднэ” гэхэд “мэднэ” гэдэг нь болох гэж байгаа үйлийг тааварлаж байгаа баймж утгатай. - Үндэс язгуурыг бүрэн ба бүрэн бус давтдаг. Жишээ нь: “бодон бодон”, “харж харж”, “яв явсаар” гэх мэт - Орон цаг, тоо хэмжээ, шалтгаан, адилтгах утгыг заана. Жишээ нь: “тэнгэр мэт”, “гэрээ ёсоор”, “аяга төдий”, “ширээн дээр”, “зам дээгүүр”, “хийхийн өмнө”, “гэрийн гадаа” гэх мэт - Уг юмын шинж чанарын харьцангуй давуу зэргийг илтгэнэ. Жишээ нь: “ув улаан”, “хамгийн том”, “цагаанаас цагаан”, “айхын ихээр айх” гэх мэт Утгазүйжсэн холбоо үгсийг эх өгүүлбэрээс дараах онцлогоор нь ялган таньж, утга бүтцийг нь тайлбарлана. - Дүрслэх ур маягаар бүтэж, нэг утга илтгэнэ. Жишээ нь: “модон хэл” гэхэд “яруу бус өгүүлэх” гэсэн утгатай бөгөөд “модоор хийсэн мэт хөшүүн хэл” гэж адилтгаснаас үүсжээ. - Түүхэн шинжтэй буюу урт хугацааны явцад бий болсон байдаг. Жишээ нь “дугуй нөхөх” гэхэд машин техник нэвтэрсэн үеэс бий болсон бөгөөд “машинд дайруулах” гэсэн утгатай. Далд утгатай хэлцүүд орно. Жишээ нь “ам алдах”, “морь харах”</p>	<ul style="list-style-type: none"> - Төрөл бүрийн найруулгын эх, өгүүлбэр - Үгийн санжсан - Утга зүйжсэн - Хэл зүйжсэн үгсийн жишээ, жагсаалт
<p>10.46. Ойролцоо, эсрэг утгатай цогцолборыг тодорхойлох</p>	<p>Ойролцоо ба эсрэг цогцолборыг ялгах, таних, хэрэглэхдээ харьцуулан тайлбарлаж бичих чадварын хүрээнд анхаарлаа хандуулна. - Эсрэг ойлголтыг хэрхэн харьцуулах - Ойролцоо ойлголтыг хэрхэн жишиж бичсэнийг тайлбарласан эсээг задлан шинжлэх явцад ойлголтоо нэмэгдүүлнэ. Үүний тулд: - Ойролцоо утгат цогцолборыг эхээс таних - Цогцолборуудын утга ойролцоо болохыг тайлбарлах - Хөрөг найруулалд дүрийн гадаад, дотоод шинжийг дүрслэн бичихдээ өгүүлэгчийн үзэл бодол хэрхэн илэрснийг ойролцоо эсрэг утгын түвшинд анхаарна. Уран зохиолын эхийн хувьд: - Ойролцоо ба эсрэг утгат цогцолборыг эхээс таних -</p>	<ul style="list-style-type: none"> - Зүйр цэцэн үг - Сургаал үг - Оньсого - Хэлц өгүүлбэрүүд

	<p>Цогцолборуудын утга ойролцоо эсрэг болохыг тайлбарлах - Үгийн зүйлчилсэн утгыг тайлбарлах</p> <p>Ойролцоо утгат цогцолбор - Хулсан ташуур нь байгаасай Хуруундаа өлгөөд явах юм сан Хууль цаазгүй ч болоосой, гээгээ минь дээ хө Хуучин нутаг Шанддаа очих юм сан, яамай даа - Яргай ташуур нь байгаасай Янзын олоод барих юм сан Ял цаазгүй ч болоосой, гээгээ минь дээ хө Яргайтынхаа голд очих юм сан, яамай даа Эсрэг утгат цогцолбор</p> <p>Энэ айлын баруун талд том эсгий гэр, ар биеийг саяхан шинэлсэн тул хойноос нь харвал дун цагаан бөгөөд хар хялгасан оосор бүслүүр татсан нь зураг мэт зурайна. Өмнөөс харвал, ноднин жилийн арын бүрээсийг сольж хийсэн нь утаа ба бороонд баахан шарласан тул буурангуй цайвар харагдана. Гэрийн хойд талд умраас өмнө хандуулсан хасаг тэрэг, сүйх тэрэг, төмөр тэрэг, цүүвэн тэрэг, хорид тэргийг цувруулан угсаржээ. Түүний дор мөөр тэнгэлэг, хигээс, банз, буулга, тэмээний шат, эвдэрсэн агаруу, торх хувин зэрэг элдвийн юмсыг нэг дор овоолсон үзэгдэнэ. Мөн тэрэгдээс зүүн хойш чонын аюулаас хамгаалдаг, орой дээрээ салхин сэнстэй онгор хар мануул байв. Хотын зүүн ба хойд талаар мануулаас өндөргүй майжгий бор гэрүүд нарны гэрэлд ханаа яралзуулж, салхины ширүүнд үнсээ бужигнуулж байлаа. Адаг зүүн өмнө аргийн чинээ хар овоохой хаяа ба тооноор зэрэг зэрэг хар утаа бургилж, гадна нь хэдэн муу тэрэг, дэргэд нь дэлүүн чинээ аргалыг дээлийн өөдсөөр бүтээсэн байжээ. Баян айлын барлаг, багир хар гэрүүдийн нэг нь Долгорын гэр ажээ. Гаднаа хэдэн муусайн тэргийг үхсэн малын яс шиг тахиралдуулан угсраад дундах бяцхан зайнд хэдэн тугал уяна.</p>	<ul style="list-style-type: none"> - Монгол ардын дууны шүлгүүд - Яруу найраг - Эртний сургаалын шүлгүүд
<p>10.4в. Хуучирсан, шинэ, гадаад, албаны, мэргэжлийн үг зэргийг найруулгад хэрэглэх</p>	<ul style="list-style-type: none"> - Хуучирсан, шинэ, гадаад, албаны, мэргэжлийн үг зэргийг таних, ялгах - Эхийн сэдэв зорилгод тохируулан үг сонгох - Хуучирсан, шинэ, гадаад, албаны, мэргэжлийн үг зэргийн найруулгын үүргийг тодорхойлох - Хуучирсан, шинэ, гадаад, албаны, мэргэжлийн үг зэргийг найруулгад зөв сонгох, хэрэглэх - Орчин цагийн монгол хэлний утга зохиолын хэлнээ утгын шинэ өнгө аясаар аль ч найруулгад орох боломжтой үгсийг ялгаж хэрэглэх - Хуучирсан үгсийг хэрэгтэй үед нь оновчтой ашиглах - Сэргээн хэрэглэж байгаа хуучирсан үгс нь үгийн сангийн хувьд эртний үг болох боловч хэрэглэгдэх хүрээ нь өргөсөж нийтийн хүртээл болж байдгийг ойлгож, хэрэглэх - Үгийн баялгаа нэмэгдүүлэх, толь хөтлөх, эх зохиохдоо ашиглах - Хуучин үг хэллэг ямар найруулгад ямар ямар үүрэгтэй байгааг тодорхойлох - Тухайн үг хэллэг хуучирсан эсэхийг дүгнэн ярилцах - Хуучирсан үг хэллэгийг найруулгад оновчтой сонгосон эсэхийг тодорхойлох 	<ul style="list-style-type: none"> - Уншиж судалж буй төрөл бүрийн найруулгын эхүүд

	<ul style="list-style-type: none"> - Хэдийгээр хуучирсан үг хэллэг нь мөн боловч өнөөгийн утга зохиолын хэлэнд нэлээд ордог, утга, үүрэг нь тодорхой мэдэгдэж байгаа үг хэллэгийг сонгон хэрэглэх - Үгсийн илэрхийлэх утга хэзээ анхлан ярьж бичих болсныг тайлбарлах - Эхээс шинэ үг хэллэгийг олох, найруулгын үүргийг тодорхойлох - Гадаад үг хэрэглэсний учир холбогдлыг тодорхойлон орчуулах боломжтой эсэхийг ярилцах - Эхэд орсон гадаад үг оновчтой эсэхийг нягтлах оновчгүйг нь солин найруулах - Эрдэм шинжилгээний найруулгад гадаад үг нэр томъёо ямар үүрэгтэй байгааг дүгнэж ярилцах - Яриан дахь гадаад үгийн үүргийг шүүмжлэн ярилцаж найруулгыг засан сийрүүлэх - Гадаад үгийг хэрхэн орчуулан найруулсан үүний учир холбогдол юу болох тухай ярилцах - Албан бичгийн эхэд байгаа албаны үгийн үүрэг хэрэгцээг тодорхойлох - Зохиол дахь албан үг хэллэгийн өнгө аясыг ярилцаж уран сайхны найруулгад нийцүүлэн засах - Эхээс албархаг үг ямар үүрэгтэйг байгааг тайлбарлах - Уран зохиолын эхэд дүрийн үг ярианд албархаг үг хэллэгийг ямар үүргээр сонгосныг тайлбарлах - Радио телевизийн нэвтрүүлэг болон илтгэл сурталчилгаа хийсэн хүний ярианаас албархаг үг хэллэг оновчгүй орсон жишээг олж тайлбарлах - Мэргэжлийн үг хэллэгийг жагсаан бичих - Ямар мэргэжлийн үг хэллэг ямар үүрэгтэй орсныг тодорхойлох - Мэргэжлийн үг хэллэгийг дүрээ гаргахад хэрхэн сонгосныг тайлбарлах <p>Багшид зөвлөх нь: Дараах тайлбарыг бүтээлчээр ашиглана. Хэлний идэвхгүй үгсийн бүрэлдэхүүнд багтаж байдаг үгсийн нэг хэсэг нь хуучирсан үг юм. Хэлний хөгжлийн явцад нэг үг хэллэгийг ойролцоо утгатай өөр идэвхтэй үг хэллэг шахан түрснээс болж улмаар огт хэрэглэгдэхгүй болсон юм уу, маш ховорхон орох болсон үг хэллэгийг хуучин гэж нэрлэдэг. Эдгээр үг хэллэг нь найруулгад ховор орох учир хүн болгонд ойлгомжтой байдаггүй. Энэ шалтгаанаас нь үндэслэн хэл найруулгад аль болох бага хэрэглэж ойлгомжгүй үг олшрохоос зайлсхийхийг чухалчилдаг. Гэвч хуучин үг хэллэгийг хэд хэдэн үүргээр хэрэглэдэг. Өнгөрсөн үеийн түүхт үнэн байдал, үйл явдал, хүний дүр төрхийг бодитойгоор дүрслэн үзүүлэх, уран зохиолын баатрын хэл ярианы онцлогийг гарган, уг баатрын тухай тодорхой төсөөлөл бий болгохын тулд үг ярианд нь тэр үеийн үг хэллэгийг хэрэглэдэг. Үг ярианд сүрлэг ёсорхуу, ойр зуурын ярианаас эрс ялгаатай, бичиг судрын уур амьсгал оруулах зорилгоор хэрэглэнэ. Зарим хуучирсан үгийн утгыг шинэчлэн орчин цагийн монгол хэлэнд сэргээн хэрэглэсэн байдаг. Жишээ нь: Нийгмийн зүтгэлтэн</p>	<ul style="list-style-type: none"> - Сонгодог бичгийн хэлний найруулгаар монгол бичгээр бичсэн төрөл бүрийн эхүүд - Эсээ - Нийтлэл
--	--	---

төрийн тэргүүн нарыг хүндэтгэхийн үүднээс бараа бологсад, эрхэмсэг ноён, зарлиг, бараалхах зэрэг үгсийг хэрэглэж байна. Энэ бол хуучирсан үгийг хэл найруулгад хэрэглэх хамгийн өвөрмөц тохиолдол юм. Хуучин үг хэллэг нь орчин цагийн монгол хэлэнд орохдоо хуучирсан шинжээрээ гурван янз байдаг. Энэ нь найруулгад анхаарч үзвэл зохих зүйлийн нэг юм.

Шинэ үг: Нийгмийн хувьсан хөгжихийн дагуу нийгмийн ахуйд шинэ юм үүсэж, хуучин юм алга болж байдаг хуулийг дагаж, нийгмийн үзэгдэл болсон хэлд тэр шинэ юм ойлголтыг тэмдэглэсэн үг бий болж, хуучин юм ойлголтыг тэмдэглэсэн үг үгүй болж байдаг нь хэлний зүй тогтол юм. Аливаа юмс үзэгдэл шинээр буй болсныг тэмдэглэсэн үг хэллэлийг шинэ үг хэллэг гэнэ. Орчин цагийн монгол хэлэнд шинэ үг үүсэх хэд хэдэн арга байдаг. Нийгмийн ба хүмүүсийн амьдралд бий болж байгаа шинэ юм үзэгдэл чанарыг дагаж түүнийг нэрлэсэн үг үүсдэг. Жишээ нь: Сансар судлал, замын бөглөө гм Хуучин байсан юм үзэгдлийг өөр үгээр нэрлэн байсан үгийн утгын хүрээг тэлэх замаар шинэ үг үүснэ. Жишээ нь: Сурагч, эмч, үзэсгэлэн Орчуулгаас шинэ үг үүсэх тохиолдол бий. Жишээ нь: Х.Пэрлээ “Конёк горбунок” хэмээх үгийг **бөгрөгтэй** морьхон хэмээн орчуулсан. Үг хурааж шинэ үг бүтээдэг. Жишээ нь: Нягтлан бодогч – нябо Шинэ үг хэллэг найруулга зүйд өвөрмөц үүрэгтэй. Ерөөс шинэ үг хэллэг гэдэг харьцангуй ойлголт юм. Шинэ үг хэллэгийн үүссэн цагийг тогтоож болох боловч шинээрээ байх нь ховор байдаг. Шинэ үг хэллэг тодорхой мэргэжлийн найруулгад үүсэж тухайн найруулгад ороод аажмаар утга зохиолын хэлд орж хэвшдэг. Шинэ үг хэллэгийн нэг хэсэг нь зохиогчийн шинэ үг хэллэг юм. Шинэ үг хэллэгийг зохисгүй хэрэглэх юм уу шинэ үгийг оновчгүй зохиовол найруулгын яруу сайханд харшилдаг.

Гадаад үг: Аливаа хэлэнд нэвтрэн орсон гадаад үгс нь найруулгын өнгө аяс, сонсогдох байдал, илэрхийлэх утгаараа тухайн хэлний үндсэн үгсээс ялгарч байдаг. Монгол хэлэнд орсон гадаад үгийг хэл найруулгад ямар зорилгоор, хэрхэн хэрэглэхийг мэддэг байх хэрэгтэй. Гадаад хэлний үгсийг их хэрэглэх нь хэлний найруулгын өвөрмөц онцлог яруу сонсголонтой, ойлгомжтой энгийн шинжид, хэлний цэвэр байдалд харшилна. Гадаад үгийг зүй зохисгүй, оновчгүй чамирхан хэрэглэхээс татгалзах хэрэгтэй. Гадаад үгийн боломжтойг нь эх хэлний дүйх үгээр орчуулан найруулгын өвөрмөц шинжид нийцүүлэн найруулах учиртай. Гадаад хэл мэддэгээ харуулах мэт харь хэлний үг илт их хэрэглэж тухайн юм үзэгдлийг нь заасан утга төгөлдөр байсаар байтал эрлийзжүүлэн ярьдаг нь ярианы найруулгыг буртаглаж байгаа хэрэг юм. Гадаад үгийг хэл найруулгад оруулан найруулж болох хэдэн тохиолдол бий.

Тодорхой мэргэжлийн явцуу нэр томъёог, олон улсын дундын шинжтэй болсон үгсийг, уран

	<p>зохиолын найруулгад зохиолын баатрын үг хэлний ялгааг гаргах, дүрийг тодруулах зорилгоор хэрэглэж болдог. Албан үг хэллэг: Эдгээр үг нь албан бичиг тушаал тогтоолд орж хэвшсэн үг хэллэг юм. Албан бичиг зохиолд зохих хэмжээгээр орох боловч эрдэм шинжилгээний болон сонин нийтлэл уран зохиолын найруулгад бараг ордоггүй. Уран зохиолын хэлний уран яруу чанарыг сулруулж үгийн дүрслэн илэрхийлэх сэтгэл хөдөлгөх шинжийг гээдгээрээ найруулгад харшилдаг. Жишээ нь: Ажлын шугамаар, захиргааны зүгээс анхааран үзэх, хариуцлага хүлээлгэх, шаардагдах арга хэмжээ авах. Мэргэжлийн үг хэллэг: Тодорхой нэг салбарт ажилладаг хүмүүсийн ажил төрлийн үг хэллэгийг мэргэжлийн үг хэллэг гэнэ. Энэ үг хэллэг нь эрдэм шинжилгээний зохиолын найруулгад элбэг байдаг уран зохиолын найруулгад мэргэжлийн хүний дүрийг үнэмшилтэй амьд тодорхой гаргах зорилгоор хэрэглэдэг</p>	
<p>10.4г. Үгийн сангийн найруулгын алдааг таних, онцлогийг тайлбарлах, алдааг залруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Үгийн сангийн найруулгын алдааг таних, тодорхойлох - Үгийн сангийн найруулгын алдааг залруулах - Үгийн утгыг ойлгож хэрэглэх - Ойролцоо утгатай үгийг зохистой хэрэглэх - Ижил үгийг хэрэглэх - Үгийн салаа утгыг ойлгож хэрэглэх - Шинэ үгийг хэрэглэх - Хуучин үгийг хэрэглэх - Харь үгийг хэрэглэх - Нутгийн аялгууны үг хэллэгийг хэрэглэх - Мэргэжлийн болоод албаны үгийг зохистой хэрэглэх - Хэлцийг хэрэглэх 	<p>Төрөл бүрийн найруулгын эх, өгүүлбэр</p>